

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН НЭГДҮГЭЭР ХЭЛТСЭЭС
2017 ОНД ДЭВШҮҮЛСЭН БОДЛОГО, ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД
ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2017.12.12

Улаанбаатар хот

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар

Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны болон бусад хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд хүний эрх эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах, шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг ашиглах, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх үндсэн зарчмыг баримтлан ажиллаа.

Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсээс гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох, шалгаж шийдвэрлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авч, хохирсон иргэдийн эрх ашгийг сэргээх, хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх, хохирсон иргэнийг гомдоохгүй үйлчлэхийг үндсэн зорилгоо болгож, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмуудыг удирдлага болгон ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Нийслэл, дүүргийн засаг дарга болон дээд шатны байгууллагаас Цагдаагийн байгууллагын болон гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаатай холбоотой үүрэг, даалгавар, тогтоол, шийдвэр, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, биелэлт үр дүнг тооцож ажилласан.

Хэлтсийн 2016 оны тайланг иргэдэд тавих хурлыг 2017 оны 01 дугаар 13-ны өдрийн 10.00 цагт Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Тэнгис” кинотеатр зохион байгуулж, хуралд ЦЕГ-ын Гэмт хэрэгтэй тэмцэх газрын албаны дарга, цагдаагийн хурандаа Д.Батсайхан иргэний зөвлөлийн гишүүд оролцсон. Хурлын үер хариуцсан дүүргийн 1-9 дүгээр хорооны иргэдэд 2016 онд хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж, санал хүсэлтийг нь хүлээн авч, судалгаа аван ажилласан ба хурлын танилцуулгыг Нийслэлийн цагдаагийн газар, Дүүргийн засаг даргын тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд гүгд оубаууу обуа-еёаа иубаеёеёуб, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч гэмт хэрэг зөрчил ихээр үйлдэгддэг эмзэг цэгүүдийн судалгаанд түшиглэн эргүүлийн чиглэл, хувиарийг хийж өдрийн цагаар хэсгийн байцаагч, олон нийтийн цагдаагийн ажилтан, хорооны цагдаа нар эргүүлийн үүргийн тогтмол гүйцэтгүүлж хяналт тавьж ажиллаж байна.

Хоёр: Гэмт хэргийн нөхцөл байдлын талаар /шинэ хуулиар/

Гомдол мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаар:

Тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт 2017 оны 07-11-р сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас хүлээн авсан 5137, урьд оны үлдэгдэл 273, нийт 5410 гомдол мэдээллийг шалгаснаас 5344 буюу 98,8 хувийг шийдвэрлэсэн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй 3177 буюу 58,7 хувийг, зөрчлийн шинжтэй 2233 буюу 41,3

хувь нь байгаа 66 гомдол мэдээлэл шийдвэрлэгдээгүй үлдэгдлээр байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 3177–г хүлээн авч үүнээс 3121 буюу 98,2 хувийг нь шийдвэрлэсэн. 1297 буюу 41,6 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, 1822 буюу 58,4 хувьд хэрэг нээхээс татгалзах санал гаргасан, Харьяаллын дагуу 2 буюу 0,06 хувийг шилжүүлэн шийдвэрлэсэн байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллээс шийдвэрлээгүй гомдол мэдээлэл 56 байна. Нийт шийдвэрлэсэн 3121 гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 1510 буюу 48,4 хувийг 5 хоногт, 6 ба түүнээс дээш хоногт 1611 буюу 51,6 хувийг шийдвэрлэсэн байна. Бүх хүлээн авсан гомдол, мэдээллийг бусад дүүргийн цагдаагийн хэлтсүүдтэй харьцуулбал 9-р байрт байна.

Гэмт хэргийн нөхцөл байдлын талаар

Тус цагдаагийн хэлтсээс 2017 оны 07-р сард шинэ хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш тус дүүргийн хариуцсан нутаг дэвсгэрт 669 гэмт хэрэг бүртгэгдэж, хэрэг бүртгэлийн хэрэг 651, мөрдөн байцаалтын хэрэг 18 бүртгэгдсэн байна. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг 117 бүртгэгдэж хэргийн илрүүлэлт 18 хувьтай, илрээгүй 534 гэмт хэрэг байна. Бүртгэгдсэн нийт гэмт хэргээс 513 буюу 76,7 хувийг хөнгөн, 156 буюу 23,3 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 18,8 хувьтай, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 15 хувьтай байна. 2017 оны эхний 11 сарын байдлаар өссөн дүнгээр 1279 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17 хэргээр буюу 1,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хэргийн илрүүлэлт эхний 11 сарын байдлаар 35,8 хувьтай байгаа нь бусад дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдтэй харьцуулахад 2-р байрт байна. Гэмт хэргийн илрүүлэлтийг бусад цагдаагийн хэлтсүүдтэй харьцуулахад 4-р байрт байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 7 буюу 1 хувийг, мансуурсан үед үйлдэгдсэн гэмт хэрэг 2 буюу 0,3 хувийг, хүүхэд оролцсон гэмт хэрэг 23 буюу 3,4 хувийг, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 45 буюу 6,7 хувийг, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 300 буюу 4,5 хувийг эзэлж байна.

Гэмт хэрэгт 149 хүн холбогдон шалгагдсаны 16 нь согтуугаар, 31 нь эмэгтэй хүн, 17 нь хүүхэд байна. Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо 625 байгаагаас эмэгтэй хүн 310, хүүхэд 64 байна. 2017 оны 07-11-р сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад 12836,4 тэрбум төгрөгний хохирол учирч үүнээс 1389,5 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт хэлтсийн хэмжээнд 10,8 хувьтай байна. 2017 оны 07-11-р сард бүртгэгдсэн нийт гэмт хэргээс даваа гаригт 120 буюу 17,9 хувь, мягмар гаригт 100 буюу 14,9 хувь, лхагва гаригт 111 буюу 16,6 хувь, пүрэв гаригт 90 буюу 13,4 хувь, баасан гаригт 94 буюу 14 хувь, бямба гаригт 88 буюу 13,1 хувь, ням гаригт 66 буюу 9,8 хувь нь тус бүр үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг үйлдэгдсэн цагаар нь авч үзвэл: 06-14 цагт 234 буюу 35 хувийг, 14-19 цагт 233 буюу 34,8 хувийг, 19-22 цагт 73 буюу 10,9 хувийг, 22-06 цагт 129 буюу 19,3 хувь нь үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргээс гэр орон сууцанд 139 буюу 20,8 хувийг, гудамж талбайд 188 буюу 28,1 хувийг, олон нийтийн газар 128 буюу 19,1 хувийг, нийтийн тээвэрт 5 буюу 0,7 хувийг, төрийн байгууллагад 9 буюу 1,3 хувийг, төрийн бус байгууллагад 3 буюу 0,4 хувийг, аж ахуй нэгж 97 буюу 14,5 хувийг, бусад газар 70 буюу 10,4 хувийг авто замд 30 буюу 4,5 хувь нь тус тус үйлдэгдсэн байна.

Гурав: Захиргааны зөрчлийн талаар /шинэ хуулиар/ 7-11 сар/

Тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт 2017 оны 7-11-р сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас хүлээн авсан 5137, урьд оны үлдэгдэл 273, нийт 5410 гомдол мэдээллийг шалгаснаас 5344 буюу 98,8 хувийг шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэгдээгүй үлдэгдэл гомдол, мэдээлэл 66 буюу 1,2 хувь нь байна. Үүнээс

зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 2233 буюу 41,3 % эзлэж байна. Зөрчлийг хувааж үзвэл 911 буюу 40,8 хувь нь ердийн зөрчил, 564 буюу 25,2 хувьд зөрчлийн хэрэг нээсэн, 160 буюу 7,2 хувийг баривчлах, 587 буюу 26,3 хувьд зөрчлийн хэрэг нээхээс татгалзах санал гаргасан, 1 буюу 0,04 хувийг харъяаллын дагуу шилжүүлсэн, 2223 буюу 99.6 хувийг шалган шийдвэрлэсэн, 10 буюу 0,4 хувийг шийдвэрлээгүй байна.

Хүлээн авсан захиргааны зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь харуулбал; Гомдол, мэдээллийн 75,9 хувийг 3 хоногт, 4 ба түүнээс дээш хоногт 24,1 хувийг шийдвэрлэсэн байна. Бүх хүлээн авч шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг бусад дүүргүүд дэх цагдаагийн хэлтсүүдтэй харьцуулбал; бүх хүлээн авсан гомдол, мэдээллээр 6-р байрт, шийдвэрлэсэн гомдол, мэдээллээрээ 6-р байрт байна.

Захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлт:

Бүртгэгдсэн нийт 964 зөрчлөөс 697 хүн буюу 72,3 хувийг торгох, баривчилсан нь 66 буюу 6,8 хувийг, зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон 30 буюу 3,1 хувийг, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 10 буюу 1 хувийг тус бүр шалган шийдвэрлэжээ. Үлдэгдэл 161 буюу 16,7 хувийг эзлэж байна.

Бүртгэгдсэн нийт зөрчил, үлдэгдэл зөрчлүүд хороогоор:

Хороо нь Нийт зөрчил 1-р хороо 107, 2-р хороо 122, 3-р хороо 126, 4-р хороо 87, 5-р хороо 105, 6-р хороо 103, 7-р хороо 157, 8-р хороо 97, 9-р хороо 60, Нийт 964 байна.

Захиргааны зөрчлийг дүүргүүд дэх цагдаагийн хэлтсүүдтэй харьцуулбал: Нийт зөрчлөөрөө 12-р байрт, шийдвэрлэсэн зөрчлөөрөө 11-р байрт тус бүр орсон байна. Зөрчлийн тухай хуулиар, Ердийн журмаар шийдвэрлэсэн нийт зөрчил 66 байгаа ба үүнээс олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах 6 буюу 9,1 хувийг, төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах 1 буюу 1,5 хувийг, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль зөрчих 28 буюу 42,4 хувийг, бусад хуулиар 31 буюу 47 хувийг тус бүр шийдвэрлэсэн байна. Зөрчлийн хэрэг үүсгэн шалгасан зөрчил нийт 697 торгосон хүн 631 баривчилсан 66

Захиргааны зөрчил үйлдэгдсэн газар, зөрчлийн тоо

Гэр орон сууцанд 156 буюу 22,4 хувийг, гудамж талбайд 319 буюу 45,8 хувийг, зам 2 буюу 0,3 хувийг, олон нийтийн газар 187 буюу 26,8 хувийг, төрийн байгууллагад 5 буюу 0,7 хувийг, төрийн бус байгууллага 1 буюу 0,1 хувийг, аж ахуй нэгжид 14 буюу 2 хувийг, бусад газар 13 буюу 1,9 хувь нь тус тус үйлдэгдсэн байна.

Захиргааны зөрчлийн үйлдэгдсэн гариг нь:

Шийдвэрлэсэн нийт 763 зөрчлийн 102 буюу 13,4 хувь нь даваа гаригт, 118 буюу 15,5 хувь нь мягмар гаригт, 179 буюу 23,5 хувь нь лхагва гаригт, 118 буюу 15,5 хувь нь пүрэв гаригт, 117 буюу 15,3 хувь нь баасан гаригт, 47 буюу 6,1 хувь нь бямба гаригт, 82 буюу 10,7 хувь нь ням гаригт тус бүр үйлдэгдсэн байна.

Захиргааны зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа нь:

Бүртгэгдсэн захиргааны зөрчлийн үйлдэгдсэн цагаар нь: 06-12цагт 152 буюу 19,9 хувь, 13-18 цагт 163 буюу 21,4 хувь, 19-24 цагт 332 буюу 43,5 хувь, 01-05 цагт 116 буюу 15,2 хувь нь үйлдэгдсэн байна. Захиргааны зөрчил 2017 оны эхний 11 сард өссөн дүнгээрээ нийт 11,473 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3548 зөрчлөөр буюу илрүүлэлт 23,6 хувиар буурсан. Шалган шийдвэрлэсэн захиргааны зөрчлөөс лхагва гаригт, 19-24 цагт ихэнх хувь нь үйлдэгдсэн байгааг цаашид анхаарч нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаандаа ашиглан ажиллахыг зөвлөж байна.

Дөрөв: Санхүүгийн албаны чиглэлээр

Төсөв гүйцэтгэл, цалинтай холбоотойгоор:

Алба хаагчдын цалин хөлсийн Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдон гарсан стандарт, журам, зааврын дагуу сард 2 удаа буюу тухайн сарын 10, 25-нд бодож олгосон ба жилд 24 удаа цалин хөлсний тооцоо хийгдсэн. 2017 оны улсын төсөвт “цалин” зардлын ангилалд 1 тэрбум 919,2 сая төгрөгийн төсөв батлагдсан. Цалингийн бодолт задаргаа Үүнд:

Алба хаагчдын ээлжийн амралтыг олгохдоо Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу бодож, ээлжийн амралттай, чөлөөтэй, өвчтэй байгаа алба хаагчдын цалин, хоолны мөнгийг давхардуулан олгохгүй мөн алба хаагчдын цалингийн нэмэгдлийг цалингийн тодорхойлолт, хүний нөөцийн нэгжээс ирүүлсэн тушаалтай тулган эрх бүхий албан тушаалтны гарын үсэг бүхий баримтыг үндэслэн бодож олгох, ажлын үр дүнгээр цалин нэмж хасахдаа тэнцвэрт байдлыг ханган, Ээлжийн амралтын тооцоог 2 амралтын хоорондох 12 сарын ажилласан хоногийн дундажаар дундаж цалинг олох замаар 150 алба хаагчдын 158 сая төгрөгийн ээлжийн амралт мөнгө олгогдсон, Эмнэлэгийн хуудасын тооцоог гаргахдаа Хөдөлмөрийн чадвар түр алдахаас өмнөх тасралтгүй ажилласан 4 сарын цалингийн дундажаар бодож 9 алба хаагчдын 1,4 сая төгрөгийн листний мөнгө олгогдсон, Холбооны зардал хүрэлцэхгүйн улмаас алба хаагчдад олгогддог нэгж байхгүй болсон бөгөөд 210801 дансны ангилалаар хэлтсийн суурин утас болон жижүүрийн утаснуудын сунгалтыг хийгээд явж байна. Цалингийн зардлыг задлаж үзвэл: Бодогдсон цалин-804 сая төгрөг, Цол- 218 сая төгрөг, Удаан жил-82 сая төгрөг, Онцгой алба-189 сая төгрөг, Тушаалаар алба хаагч-43 сая төгрөг нэмсэн, 6 сая төгрөг хассан, Цалин дээрх хоол-13 сая төгрөг, Бусад тооцоо 23 сая төгрөг нийт Цалингийн сангаас 1531 сая төгрөг гарсан байна. Цалингаас Шүүхийн шийдвэрээс өөр суутгал хийгдээгүй болно.

Хөрөнгө оруулалт, төсвийн гүйцэтгэл: 2017 онд Дүүргээс 54 сая төгрөгийг үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй ирсэн бөгөөд орлогын тайлан болон холбогдох баримт бичгийг бүрдүүлэн авсан болно. ЦЕГ-н СААА-с 2,519,020 төгрөгийн үндсэн хөрөнгө, ЦЕГ-ын ХҮТасгаас 4,619,855 төгрөгийн тусгай зориулалтын материал, 1,174,500 төгрөгийн бичиг хэргийн материал, Нийслэлийн цагдаагийн газраас 1,359,800 төгрөгийн үндсэн хөрөнгө, 735,000 төгрөгийн бичиг хэргийн материал, 470,000 төгрөгийн бусад хангамжийн материал, 350,000 төгрөгийн шатахуун, 3,783,407.50 төгрөгийн Олон Нийтийн Цагдаагийн хувцас, 2,597,508 төгрөгийн тусгай зориулалттай материал тус бүрийг авч орлогын дансанд бүртгэж хүлээн авч холбогдох тооцоо судалгааг хийж ажилласан. 2017 он Сонгуулийн жил байсан учир сонгуультай холбоотойгоор алба хаагчдын үүрэг гүйцэтгэх хугацаанд шатахуун, хоолны мөнгөний судалгааг тухай бүрт хийж ЦЕГ-аас 8,3 сая төгрөгийн санхүүжилт ирсэнийг алба хаагчдад тараан олгож тооцоог дуусгасан. 2017 оны байгууллагын хөрөнгө тооцоо Бараа материал 131,4 сая төгрөг, Үндсэн хөрөнгө 1 тэрбум 637 сая төгрөг, үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 1,636 сая төгрөг. Улсын төсвөөс 2 тэрбум 84 сая төгрөг, Цагдаагийн байгууллага хоорондын хөрөнгөөр 10 сая төгрөг, материалаар 22,2 сая төгрөг, тус тус санхүүжилт орж ирсэн бөгөөд дараах төрлийн зардал гарсан Тус хэлтэст 1,626,744,400 төгрөгийн төсвийн урсгал санхүүжилт хувиарлагдсан. Үүнд: Үндсэн цалин 1,464,672,387 төгрөг, Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл тэтгэврийн даатгал 29,190,428 төгрөг, Хоол, хүнс 13,857,653 төгрөг, Нормын хувцас, зөөлөн эдлэл 875,347 төгрөг, Бичиг хэрэг 6,483,503 төгрөг, Тээвэр шатахуун 65,796,600 төгрөг, Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 119,597 төгрөг, Гэрэл цахилгаан 8,847,188 төгрөг, Түлш, халаалт 6,745,867 төгрөг, Цэвэр бохир ус 2,244,206 төгрөг, Багаж, техник, хэрэгсэл 2,956,564 төгрөг, Урсгал засвар 8,043,436 төгрөг, Бусдаар

гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбар хураамж 4,138,300 төгрөг тус бүрийн гүйлгээ гарсан болно.

Батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлтэй холбогдох ажлууд, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах: 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангуудыг аудитын газарт хүргүүлж зөвлөмж, чиглэл авч ажилласан бөгөөд 7-р сард аудитын зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хүргүүлсэн. 2017 оны 1-09 сарын хооронд завсарын аудит орж биет тест хийж 3 төрлийн зөвлөмж, заавар өгсөн бөгөөд хийж гүйцэтгэсэн ажил болон санхүүгийн 43 баримтыг аудитын газар хүргүүлж одоо шалгалтын ажил явагдаж байна. 2016 онд Жижиг мөнгөн сангаар 3,5 сая төгрөг орсон үүнд: Ахмад алба хаагчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний мөнгийг зарцуулсан. Сар бүрийн 1-нд төсвийн өр авлагын тайлан дээд шатны төсөв захирагч нарт хүргүүлж ажилласан, 2017 онд дараах өр авлага тусгагдсан: 1-р сарын байдлаар бичиг хэрэг, тээвэр шатахуун, тогтмол зардал хүрэлцэхгүй нийт өр төлбөр 2,950 мянган төгрөг болсон, 2 сард бичиг хэрэг, тээвэр шатахуун, тогтмол зардал 4,037 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн 3-р сард бичиг хэрэг, тээвэр шатахуун, тогтмол зардал 2,690 мянган төгрөг, 4-р сард 1,673 мянган төгрөгийн өртэй гарсан. 5-р сард 1,502 мянган төгрөг 6-р сард 3,362 мянган төгрөг, 7-р сард 3,086 мянган төгрөг, 8-р сард 13,398 мянган төгрөг, 9-11-р саруудад өр төлбөр төсвийн хөдөлгөөнөөр бүгд барагдсан бөгөөд Он дамжсан авлага байхгүй бөгөөд тухайн сард гарч байгаа. Тус хэлтэс нь Жижиг мөнгөн сангаар сар бүр гүйлгээ хийж хаалгадаггүй бөгөөд Улаанбаатар хотын банкны няравын дансаар дамжуулан 4 удаагийн нийт 3,7 сая төгрөг орсон үүнд: Ахмад алба хаагч нарыг хүлээн авах, Ахлагч бүрэлдэхүүнд хүндэтгэл үзүүлэх, жагсаал цуглаанд үүрэг гүйцэтгэж буй алба хаагч нарын хоол зэрэгт гаран зарцуулагдаж холбогдох тайлан, баримт гарсан байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах:

Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байгууллагын болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах ажил нийт 180 мэдээ мэдээллийг байршуулсан. Алба хаагчдад Шилэн дансны тухай хуулийн талаар болон код журам 135-д орсон өөрчлөлтийн талаар хичээл заасан үүгээр шилэн дансны хууль болоод вэб хуудасанд хэрхэн хандаж орж мэдээллээ хэрхэн олж авч болох талаар заасан Байгууллагын мэдээллийн самбарт мэдээллийг тухай бүр нь байршуулж нийт 6 багананд 40 удаагийн мэдээллийг байршуулж танилцуулсан мөн 11-р сард Нийслэлийн аудитын газраас 2016 оны 10-р сараас 2017 оны 10-р сарын байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгасан бөгөөд ямар нэгэн зөрчил заагдаагүй. www.chingeltei-1.police.gov.mn Байгууллагын цахим хуудасанд шилэн дансны цэс үүсгэсэн байдлыг авч үзвэл /задаргаа хийгээд мөнгөн дүн нь тоймлон авч үзвэл дараах байдалтай байна. Шилэн дансны нэгдсэн системтэй холбогдох цэс, Шилэн дансны тухай хууль, журам цэсэнд Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоол, ЦЕГ-ын даргын 2014 оны 911 дүгээр тушаал орсон, Санхүүгийн ил тод байдал цэсэнд 2017 оны төсвийн төсөл, 2017 оны санхүүгийн тайлан, 2016 оны аудитын дүгнэлт, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2017 оны 3-р улиралын санхүүгийн тайлан, Төсөв гүйцэтгэл цэс дотор 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээнд шатахууны гүйлгээнүүд 11 удаагийн 72,238 мянган төгрөгийн зарлагийн гүйлгээ, 1,771,000 мянган төгрөгийн орлогын гүйлгээг тусгасан. Төсвийн сарын мэдээ цэсэнд 1-11 дүгээр сарын “сарын мэдээ”-үүд, Хөрөнгө оруулалт цэсэнд 2017 оны 1-5 сарын хүү торгуулийн орлогын мэдээ, Тендер худалдан авалт цэсэнд дүүргийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийн тайлан, Байгууллага цэсэнд байгууллын өмч хөрөнгөтэй холбоотой 4 удаагийн тушаал% актлаж устгах тушаал 2 удаагийнх, хөрөнгө орлогод авах баримтын мэдээлэл оруулсан зэргийн байршуулсан байна. Хэлтсийн мэдээллийн

самбарт 6 төрлийн мэдээлэл байршигддаг бөгөөд сарын гүйлгээ, Төсвийн мэдээ, худалдан авалт, тушаал шийдвэр, мэдээлэл зэргээр бүгд сар бүрт шинчлэгдэн байршигддаг болно. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас www.shilendans.gov.mn/ Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтэс/ Төсөв гүйцэтгэл, худалдан авалт, бусад гэсэн багануудад мэдээлэл бүрэн байршигдсан. 3-р сар 7-8 саруудад хугацаа хоцоорон асуудал байгаа боловч байршигдах бүх мэдээлэл буюу 140 мэдээ мэдээлэл байршигдсан болно.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цагалбарын дагуу 2017 оны төсвийн төсөл 2019-2020 оны төсвийн Дунд хугацааны төсвийн төсөл боловсруулсан, батлагдсан маягт, аргачлалын дагуу 26 нэр төрлийн зардлын тооцоо судалгааг гаргаж 2018 оны төсвийн багц 2 тэрбум 401 сая төгрөг байхаар 2019-2020 оны төсөөллөөр 3 тэрбум 600 сая төгрөг байхаар тооцоолж 2017 оны 7-р дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн.

Тав. Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр

Эргүүл, хэв журмын хамгаалалтын талаар

Тус цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгаас нийт 148 удаагийн хамгаалалт зохион байгуулагдсан ба давхардсан тоогоор 1340 хүн 6700 цаг үүрэг гүйцэтгэн ажилласан. Үүнээс дүүргийн хариуцсан 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс үүрэг гүйцэтгэж буй автомашинт эргүүлийн 5 авто машинд 42 алба хаагч 46859 цаг үүрэг гүйцэтгэсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний талаар товч авч үзвэл:

Нийслэлийн хэмжээнд болон хариуцсан дүүргийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, согтуугаар үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх явдлыг бууруулж, архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас ар гэртээ агсам тавьж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч буюу архаг архичид болон архинд донтох өвчтэй иргэдэд нийгэм, сэтгэл зүйн тусламж үйлчилгээг бусад байгууллагатай хамтран нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах зорилгоор “Эрчимжүүлэлт-1” нэгдсэн арга хэмжээг 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 2017 оны 05 дугаар сарын 03-ны хооронд зохион байгуулж хариуцсан 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг 269 аж ахуйн нэгжүүдэд хяналт, шалгалт хийн ажиллан зөрчлүүдийг илрүүлэн ажиллаа. Тусгай зөвшөөрөлгүйгээр архи согтууруулах ундаагаар үйлчилсэн “Грандсоурсе” ХХК-ий “Грандлюкс”, “Грандбудда” ХХК-ий “Гранд ин” ресторан, “Аврора гэгээ” ХХК-ий “Аврора” ресторан, “Күйнскроун” ХХК-ий “Кроун” баар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 91 дүгээр тогтоолоор нийслэлийн хэмжээнд сар бүрийн 1-ний өдрийг “Архи согтууруулах ундаа худалдаалахгүй өдөр” архи согтууруулах ундаа худалдан борлуулсан “Нью Мил Стар” ХХК-ий “Мил Стар” кафе, “Шиката” ХХК-ий “DDHZ” /Kevins/ ресторанд 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 22:00 цагт архи согтууруулах ундаагаар үйлчилж байсан зөрчлүүдийг илрүүлэн АСТТХ-д зааснаар торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг, орчиндоо байнга түгшүүр төрүүлдэг архаг архичид, архинд донтох өвчтэй иргэдийн судалгаанд баяжилт хийн ЗХТХ-ийн 21 дүгээр зүйлд зааснаар 115 иргэнийг 575000 төгрөгний торгуулийн хуудсаар, 20 иргэнийг 295000 төгрөгний шийтгэврээр торгож, 9 иргэнийг баривчлуулан, удаа дараа архидан согтуурч саатуулагдсан 4 иргэнийг ЗХТХ-ийн 22 дугаар зүйлд

зааснаар, Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийн нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, мөрдөн мөшгөсөн, заналхийлсэн, бусадтай харилцахыг хязгаарласан, гутаан доромжилсон 26 иргэнийг 37-30 хоног баривчлуулан, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулинд зааснаар 3 иргэнийг 70000 төгрөгөөр торгож ажиллаа.

Согтуурах, мансуурах донтой этгээдийг архины албадан эмчилгээнд хамруулах “Албадан эмчилгээ” хэсэгчилсэн арга хэмжээг 2017 оны 04 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулж дүүргийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байнга архидан согтуурч бусдын амгалан тайван алдагдуулдаг, удаа дараа архины захиргааны арга хэмжээ авагдсан боловч давтан согтуугаар зөрчил гаргасан архинд донтох өвчтэй 15 иргэнийг Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн эмч нарын үзлэгт хамруулахад 14 этгээд тэнцэж, 1 этгээд эрүүл мэндийн үзлэгт тэнцээгүй, 5 этгээдийн нэхэмжлэл хангалтгүй гэж шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн болно. Хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Н.Дамдинсүрэн эрүүл мэндээр тэнцээгүй Э.Батжаргалыг ЗХТХ-ийн 21 дүгээр зүйлээр 15000 төгрөгний торгуулийн шийтгэврээр торгож ажилласан. Архины албадан эмчилгээнд хамрагдах шийдвэр гарган 9 иргэнийг Төв аймаг Баян суманд дахь ШШГЕГ-ны харьяа “Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан хөдөлмөр хийлгэх газар”-т хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Б.Түвшинжаргал, хороон цагдаа, цагдаагийн дэд ахлагч У.Дашням, Б.Батзаяа цагдаа жолооч, цагдаагийн ахлах ахлагч Э.Хувьзаяа нар 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр 30-12 унү улсын дугаартай Авейко маркийн автомашинаар 18-22 цагийн хооронд хүргэн өгч ажилласан. Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулиуд болон Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 102 тусгай дугаарт удаа дараа ирж буй хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн ангиллын дуудлага мэдээллийн шийдвэрлэлтэд хяналт тавих, шийдвэрлэлтийг сайжруулах, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, иргэд олон нийт, төр захиргааны байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах зорилгоор “Хонх дарж, хаалга тогшье” арга хэмжээг 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж байна. Хэлтсийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдаас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дэх хэсэгт заасан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авсан, хянан шийдвэрлэж байгаа албан тушаалтан хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний хувийн мэдээллийг нууцлах, задруулахаас урьдчилан сэргийлэх”, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журмын 3 дугаар зүйлийн 3.8 дахь хэсэг /Гомдол мэдээлэл өгсөн хүний мэдээллийг заавал нууцлана. Хөрш айл болон зэргэлдээ оршин суугчаас гаргасан гомдол мэдээлэлд мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана/-т зааснаар гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл өгсөн иргэний аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангаж ажиллах талаар бичгээр баталгаа гаргуулж авсан. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол мэдээллийг хүлээн авч хойшлуулшгүй ажиллагаа явуулахад анхаарах, хэрэгжүүлж ажиллах зааварчилгыг хэсгийн байцаагч, эргүүлийн офицеруудад 2 удаа бичиж үр дүнг тооцож ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид бичгээр өгөх тусламж, зөвлөмжийг А5 хэмжээтэй боловсруулж хохирогчид өгч ажиллаж байна. Хүчирхийлэлд өртөж хохирсон болонорон гэрээсээ дайжсан хүүхэд, эмэгтэйчүүдийг хүлээн авч, ганцаарчлан уулзах, зөвлөгөө өгөх, шаардлагатай тусламж үйлчилгээнд холбон зуучлах, байцаалт, мэдүүлэг авах өрөөг тохижуулахад 20 сая төгрөгийн зардал

гаргахаар төсөл боловсруулж, тус хэлтсийн 220 тоот өрөөг сонгож Чингэлтэй дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран тохижуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээллийг жижүүрийн дуудлага хүлээн авдаг EIN сангаас өдөр бүр шүүж хэсгийн байцаагч нарт өгч, гарч зугатаасан, шалгахад байхгүй байсан гэх дуудлага нэг бүрийг эргэн шалгаж, шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллаж байна. Чингэлтэй дүүргийн Тамгын газар, ГХУСАЗСЗ, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, ГБХЗХХ хамтран 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл Хүүхдийг зодож шийтгэхгүй өдрийг угтаж “Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг хамтдаа” аяны удирдамж боловсруулан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ЕБС-ийн 5, 23, 24, 50 дугаар сургуулийн ахлах ангийн нийт 400 сурагчид гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах байцаагч, цагдаагийн ахмад Д.Оюунчимэг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Бат-эрдэнэ, сургуулийн нийгмийн ажилтантуудтай хамтран, мөн Хөдөлмөр нийгмийн хамгааллын дээд сургуулийн 60 оюутанд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” сурталчилж сургалт зохион байгуулж, гарын авлага, зөвлөмж 80 ширхэгийг тарааж ажилласан.

Нийслэлийн Цагдаагийн газрын дэд бөгөөд Нийтийн хэв журам хамгаадах газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 14в/706 дугаартай ажлын чиглэл, 04 дүгээр сарын 20-ны өдрийн 14в/717 дугаартай Нийслэлийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Эрдэнэболд, Нийслэлийн боловсролын газрын дарга Ж.Гантулга, Монголын оюутны холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Б.Жигжид, Монголын сурагчдын холбооны гүйцэтгэх захирал Ш.Цэцэг нарын баталсан “Төгсөлт” нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг үндэслэн “Төгсөлт” нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулж төлөвлөгөөний дагуу тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. “Эрдмийн баяр” төгсөлтийн арга хэмжээ зохион байгуулагдах ажлын төлөвлөгөө, арга хэмжээ явагдах газрын судалгааг сургууль нэг бүрээр авч 2, 3, 4, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг НХДХС, СУИС, Улаанбаатар Эрдэм судлал дээд сургууль, 05, 23, 24, 50, Тоолол, Олонлог, Наран, Тусгал, Шинэ зуун билэг, Атланта, Чин хур, Шашны сургалттай Бэтүв, Бадмаараг зэрэг сургуулиуд өөр өөрийн сургуулийн орчинд төгсөлтийн арга хэмжээг явуулах судалгааг ирүүлсэн тул явган болон машинт эргүүлийн Хайрхан 112, 114, 115, 116 чиглэлийн маршрутанд тусган хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Монгол улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж байгууллагад 21 насанд хүрээгүй хүнд архи согтууруулах ундаагаар үйлчлэхгүй, архигүй үйлчилгээ явуулах талаар хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 60 аж ахуйн нэгж, байгууллагад “Албан мэдэгдэл”-ийн өгч, хяналт тавьж үр дүнг тооцож ажиллаа. “Эрдмийн баяр” тэмдэглэх тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/147 дугаартай тушаал, Нийслэлийн Боловсролын газраас 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Ерөнхий боловсролын сургуулиудын эрдмийн баяр зохион байгуулах ажлын зөвлөмж хэрэгжүүлэх, төгсөгчдийн “Боловсролын гэрчилгээ” гардуулах хүндэтгэлийн арга хэмжээ болгон зохион байгуулах, явуулж буй арга хэмжээнд эцэг эх, асран хамгаалагч нарыг заавал оролцуулах талаар зөвлөмж өгч, эрдэмийн баяр тэмдэглэх өдрүүдэд хариуцлагатай жижүүрээр ажиллах багш нарын нэрс, утасны дугаарыг авч ажиллаа. Гэмт хэрэг, зөрчил, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр СУИС болон салбар сургууль, Улаанбаатар эрдэм судлал, ХНХДС-ийн сургалтын менежер, Ерөнхий боловсролын 05, 23, 24, 50, Тоолол, Олонлог, Наран, Тусгал,

Шинэ зуун билэг, Атланта, Чин хур, Шашны сургалттай Бэтүв, Бадмаараг сургуулиудын нийгмийн ажилтануудтай хамтран төгсөх ангийн оюутан, сурагчдын дунд сургалт, мэдээллийг өгч ажиллаа. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын сургуулиуд 6 дугаар сарын 07-ны өдөр төгсөлтийн арга хэмжээг зохион явуулах шийдвэрийг дүүргийн Боловсролын газраас гаргаад байна.

Чингэлтэй дүүргийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл үйлдэрлэх, хадгалах, худалдах, импортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг шинэчлэн гаргаж, холбогдох байгууллагуудтай хамтарсан “Шалгалт” арга хэмжээг 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 22-ны хооронд зохион байгуулж алба хаагчдад химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодистой харьцахдаа аюулгүй ажиллагааны дүрмийг чанд баримтлан ажиллах үүрэг чиглэл, зааварчилгааг өгч ажиллаа. Арга хэмжээний хүрээнд дүүргийн Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтэнтэй хамтран Чингэлтэй дүүргийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 6 шатахуун түгээх станц, тэсэрч дэлбэрэх бодис хадгалдаг 146 аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааг шалган зааварчлан, судалгааг шинэчлэн гаргаж ажилласан.

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, орон сууц, гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэргийг бууруулах зорилгоор нийслэл хотод орон сууцны барилгын орц, гадна орчин гэр хорооллын гудамж, талбай зэрэг газруудыг камержуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор 1-9 дүгээр хороод, сууц өмчлөгчдийн холбоод, хөршийн хяналтын бүлгүүдийн дунд 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд “КАМЕРЖУУЛАЛТ” болзолт уралдааныг зохион байгуулсан. Дүүргийн хариуцсан нутаг дэвсгэрт хэсгийн байцаагч, хороон цагдаа, олон нийтийн цагдаа нар “Аюулгүй орчин Иргэдийн оролцоо” зурагт хуудсыг 150 ширхэгийг тарааж байрлуулсан. “Камержуулалт” болзолт уралдааны хүрээнд 2017 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 10:00-12:30 цагийн хооронд тус хэлтсийн хурлын тэнхимд дүүргийн 1-9 дүгээр хороодын Засаг дарга-9, ИНХ-ын дарга-9, СӨХ-н захирал 52 нийт 75 иргэнийг урьж оролцуулан Нийслэлийн Засаг даргын баталсан “Камержуулалт” болзолт уралдааны захирамж төсөв хөрөнгийг танилцуулан хүн бүрт хувилж өгсөн. Энэ үеэр ЧД-ийн 2 хорооны Мянгат СӨХ-ын захирал Нинжбадгартай цагдаагийн хэлтэс уулзалт хийж хариуцсан 8 орон сууц, гадна орчныг хэрхэн камержуулсан, камержуулалтын ач холбогдлын талаар ярилцлага хийсэн теле сурвалжлагыг бэлтгэн танилцуулан, мөн цагдаагийн хэлтэс СӨХ-ын байршуулсан камер, байгууллага аж ахуйн нэгжийн байршуулсан камер, дүүргийн санхүүжилтээр гудамж талбайд байршуулсан камерын тусламжтайгаар ямар хэргийг хэрхэн илрүүлсэн талаар сурталчилгаа хийж, камержуулалтыг хэрхэн хийх талаар тэргүүн туршлага солилцон санал хүсэлтийг авч ажиллаа. Уулзалтанд тус цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ө.Эрдэнэхүү, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга цагдаагийн дэд хурандаа Р.Төмөрбаатар, дүүргийн Засаг даргын орлогч Ж Чимэдцогзол, Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хороо хариуцсан дарга П.Амартүвшин, Захиргаа удирдлагын хэлтсийн хуулийн мэргэжилтэн Л.Ариунзаяа, дүүргийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажил Зохицуулах Салбар Зөвлөлийн нарийн бичгийн дарга М.Бямбазаяа нар оролцож дүүргийн Засаг даргын орлогч Ж.Чимэдцогзол болзолт уралдаанд идэвхтэй оролцохыг уриалж нийслэлд бүх СӨХ шалгарч байр эзлэх боломжгүй тул идэвхтэй оролцсон СӨХ-уудыг Засаг даргын шагналаар шагнаж урамшуулах болно гэдгийг амласан. Мөн уулзалтанд оролцсон хороон Засаг дарга, ИНХ-н дарга, СӨХ-ын захирлуудад цагдаагийн хэлтсийн

телекамерын хяналтын төвийг танилцуулан камержуулалтын ач холбогдлыг танилцуулсан. Тус цагдаагийн хэлтсийн холбооны инженер цагдаагийн ахмад Б.Оюунбаатар нь дүүргийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт камержуулах шаардлагатай газруудыг танилцуулж сүүлийн үеийн стандарт шаардлагад нийцсэн камерыг хэрхэн яаж тавих талаар зөвлөгөө өгсөн.Тус хэлтсийн “Камер”-ын хяналтын нэгдсэн төвийн үйл ажиллагааг ирсэн зочдод танилцуулж ажилласан ба дээрх үйл ажиллагааг MN 25 телевиз болон хэлтсийн цахим сайтаар сурталчилж ажилласан. Тус хэлтсийн 1-9 дүгээр хорооны Засаг дарга, СӨХ, хөршийн хяналтын бүлэг, камержуулалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага иргэдийг урьж оролцуулан болзолт уралдаанд хэрхэн оролцох санал бодлоо солилцож камерын хяналтын ач холбогдолын талаар танилцуулсны үр дүнд СӨХ-11, Хөршийн хяналтын бүлэг -1, иргэн-2, аж ахуйн нэгж байгууллага-2 нийт 16 аж ахуйн нэгж байгууллагаас 46.250.000 төгрөгний төсөвтэйгээр 190 ширхэг камерыг хариуцсан нутаг дэвсгэртээ байршуулж ажилласан. Байршуулсан камеруудаас байшин хороололд 135, гудамжинд 46, гэр хороололд 9 камераар хяналт тавьж байна. Болзолт уралдаанд идэвхтэй оролцож байгаа иргэн аж ахуйн нэгж байгууллагуудын сурталчлах зорилгоор ЦЕГ-ийн хэвлэл мэдээллийн “Дуулга” студитай хамтарч “Мянгат” СӨХ-ийн захирал М.Минжбадгар, 3 дугаар хорооны засаг дарга С.Туяа, “Авзага” СӨХ-ийн захирал Б.Гантуяа, 7 дугаар хорооны Засаг дарга Ц. Дуламжав, 7 дугаар хорооны “Хамтын хүч” хөршийн бүлгийн ахлагч М.Батсайхан нараас камержуулалт болзолт уралдаанд хэрхэн оролцож байгаа, хичнээн камер байршуулж үр дүн ямар байгаа талаар ярилцлага авч ажилласан. Камержуулалт болзолт уралдаанд цагдаагийн алба хаагчид хариуцсан нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг СӨХ, хөршийн хяналтын бүлэг, иргэн аж ахуйн нэгж байгууллагатай хэрхэн хамтарч оролцож байгаа талаар тус дүүргийн 2 дугаар хорооны хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Б.Түвшин-Эрдэнэ, 7 дугаар хорооны хороон цагдаа цагдаагийн ахлах ахлагч Ц.Өлзийтайван нар нь тус нэвтрүүлгээр ярилцлага өгч камерын ач холбогдол болон болзолт уралдаанд идэвхтэй оролцох талаар иргэдэд сурталчилсан.

Тус цагдаагийн хэлтсээс Нийтийн хэв журам хамгаалах газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Ганзориг, Нийслэлийн цагдаагийн газрын дарга цагдаагийн хурандаа Ж.Эрдэнэболд нарын хамтран баталсан “Эргүүл” нэгдсэн арга хэмжээг дүүргийн нутаг дэвсгэрт хулгай дээрэм, булаах гэмт хэрэг ихээр бүртгэгддэг хороо, эмзэг цэгүүдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлэх, эргүүлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, алба хаагчдын ажлын хариуцлага үр дүнг дээшлүүлэх зорилгоор, 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулан ажиллаа. Арга хэмжээний хүрээнд гудамж талбайн эргүүлийн хяналтанд авах ажлыг зохион байгуулснаар давхардсан тоогоор 486 чиглэлд 972 алба хаагч 32400 цаг ажилласан. Эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдаас 533 байгууллага аж ахуй нэгж, 165 тээврийн хэрэгсэл, 485 иргэнийг тус тус шалгаж, нийт 1278 зөрчил илрүүлж шийдвэрлэснээс Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21-р зүйлээр торгуулийн тасалбараар 154 хүнийг 795,000 төгрөгөөр, шийтгэвэрээр 27 хүнийг 385,000 төгрөгөөр, 42,2-р зүйлээр 896 хүнийг 4,480,000 төгрөгөөр, 32,2-1 зүйлээр 107 хүнийг 535,000 төгрөгөөр, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар 11 аж ахуйн нэгж байгууллагыг 1,040,000 төгрөгөөр, Тамхины хяналтын тухай хуулиар 10 хүнийг 50.000 төгрөгний торгууль шийтгэл ногдуулсан байна. Захиргааны зөрчил гаргасан 67 хүнийг материалжуулан шүүхэд шилжүүлсэнээс 48 хүнийг баривчлуулах, 19 хүнийг 340,000 төгрөгөөр торгуулах шийтгэл ноогдуулсан байна. Архины албадан эмчилгээнд 9 этгээдийг хамруулан, тус цагдаагийн хэлтсээс 86 офицер, 62 цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан 7, урамшилт эргүүл 12 Хамгаалалтын Нэгдүгээр газраас 4

офицер, 20 ахлагч, Хууль сахиулахын их сургуулиас 44 сонсогч, нийт 216 офицер, цагдаа сонсогч, 5 автомашин 45 гар станцтайгаар үүрэг гүйцэтгэн ажилласан. Гэмт хэрэг зөрчил үйлдэгдэн гардаг эмзэг цэгүүдийг гэмт хэргийн цахим зураглал “Cream tar” программд Мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нар шивж оруулан, зураглал болон дэд хэсгийн ахлах байцаагч нарын саналыг үндэслэн Кримнологи судалгааны баг, эргүүлийн байршлыг 14 хоног тутам хороо тус бүрээр гарган, эргүүлийн томилгоонд оруулах саналыг Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлэн ажилласан. Авто эргүүлийн алба хаагчдыг дуудлага мэдээлэлгүй үед явганаар 150 метрт эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэн рапорт тэмдэглэлд тусган үүрэг гүйцэтгэлтийг дарга, ахлахууд биечлэн болон GPS-ээр, теле хяналтын камераар хянан ажилласан. Хэлтсийн Төлөвлөлт, зохион байгуулалт, Мөрдөн байцаах, Хэрэг бүртгэх, Эрүүгийн цагдаагийн тасгуудын 70 алба хаагчдыг хуваарь томилгоонд оруулан 7 хоног бүрийн баасан гарагт эрүү, хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн 42 чиглэлд 70 алба хаагчийг 30 хүн цаг явган эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэн хяналт тавин ажиллаа. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газраас үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын, эргүүлийн чиглэлийн онцлог, үйлдэгдсэн гэмт хэргийн танилцуулга, зарлан мэдээллийг бичгээр гарган өгч, торгуулийн тасалбар, гар станц, эргүүлийн тэмдэгээр хангаж тэдний үүрэг гүйцэтгэлтэнд дарга, ахлах байцаагч нар тогтмол хяналт тавин ажлын үр дүнг тооцон ажилласан байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргон зайлсан 9 этгээдийг олж тогтоон шүүхээс иргэний хариуцагчийг олж тогтоохыг даалгасан захирамжийн дагуу 9 этгээдийг олж тогтоон. Оршин суугаа газраасаа гараад сураггүй алга болсон 12 этгээдийг олж тогтоон тус тус эрэн сурвалжлалтыг зогсоосон. Эргүүл нэгдсэн арга хэмжээний хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ж.Чулуунбаяр 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр MN-25, Монголын үндэсний телевиз, С1 телевизүүдийн мэдээний редакцид “Эргүүл” нэгдсэн арга хэмжээг хариуцсан хороодын нутаг дэвсгэрт хэрхэн зохион байгуулж байгаа болон хулгай дээрэм, булаах гэмт хэрэг ихээр бүртгэгддэг хороо, эмзэг цэгүүдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлэх, эргүүлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах талаар мэдээлэл өгч ажилласан. Дүүргийн 1-9 дүгээр хорооны хэв журмын урамшилт эргүүлүүдийг 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хүлээн авч, Нийслэлийн цагдаагийн газрын хэв журмын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ш.Батболд, мэргэжил арга зүйн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа С.Амармөрөн, нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Р.Төмөрбаатар, дэд хэсгийн ахлах байцаагч цагдаагийн хошууч М.Идэрболд, цагдаагийн ахмад М.Жамъянсүрэн, ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ж.Чулуунбаяр, хэв журмын урамшуулттай эргүүл 12 оролцож гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээлэл хэрхэн дамжуулах, тэмдэглэж авах хэсгийн байцаагч, хорооны цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтантай хамтарч ажиллах талаар үүрэг чиглэл өгч ажилласан. Эргүүл нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд гэмт хэргийн гаралт өнгөрсөн оны мөн үеийнхээс 137 нэгжээр буюу 11,8 хувиар буурсан, 2017 оны 04 дүгээр сард үйлдэгдсэн гэмт хэргийн илрүүлэлт 54,9 хувьтай, өмнөх оны мөн үеээс 3,2 хувиар өссөн зэрэг эерэг үзүүлэлт гарсан байна.

Хулгай дээрэм, булаах гэмт хэрэг ихээр бүртгэгддэг хороо, эмзэг цэгүүдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Ченж” хэсэгчилсэн арга хэмжээг 2017 оны 05 дугаар сарын 04-ны өдрөөс 09-ны өдрүүдэд Теди худалдааны төвийн гадна талд зохих звөшөөрөлгүйгээр гар утас худалдан авч, зарж борлуулдаг 14 хүний зөрчлийг материалжуулан Чингэлтэй дүүргийн шүүхээр оруулж 8 иргэнийг 7-14 хоног баривчлуулж, 6 иргэнийг шүүгчийн шийтгэврээр 90.000 төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ авч ажилласан. Мөн 34 ченжийг бүртгэл судалгаанд оруулан гарын дардсыг авч эрүүгийн цагдаагийн тасагтай хамтран ажилласан. Дүүргийн 1-9 дүгээр

хорооны хэв журмын урамшилт эргүүлүүдийг 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хүлээн авч, Нийслэлийн цагдаагийн газрын хэв журмын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ш.Батболд, мэргэжил арга зүйн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа С.Амармөрөн, нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Р.Төмөрбаатар, дэд хэсгийн ахлах байцаагч цагдаагийн хошууч М.Идэрболд, цагдаагийн ахмад М.Жамъянсүрэн, ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ж.Чулуунбаяр, хэв журмын урамшуулттай эргүүл 12 оролцож гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээлэл хэрхэн дамжуулах, тэмдэглэж авах хэсгийн байцаагч, хорооны цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтантай хамтарч ажиллах талаар үүрэг чиглэл өгч ажилласан. Эргүүл нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд гэмт хэргийн гаралт өнгөрсөн оны мөн үеийнхээс 137 нэгжээр буюу 11,8 хувиар буурсан, 2017 оны 04 дүгээр сард үйлдэгдсэн гэмт хэргийн илрүүлэлт 54,9 хувьтай, өмнөх оны мөн үеээс 3,2 хувиар өссөн зэрэг эерэг үзүүлэлт гарсан байна.

Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн дахин санал хураалттай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Сонгуулийн дахин санал хураалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/500 дугаар захирамжаар 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 00:00 цагаас мөн сарын 09-ний өдрийн 00:00 цаг хүртэл нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр зогсоож, биелэлтэнд нь хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон шийдвэр гарсантай холбогдуулан “Сонгууль-1” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Сонгуулийн дахин санал хураалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/500 дугаар захирамж, хэлтсийн даргын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 29 тоот албан мэдэгдлийг тус дүүргийн нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчилдэг нийт 358 аж ахуйн нэгж байгууллагуудад тараан ажилласан.

Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагч, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нарын хамт тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчилдэг 75 аж ахуйн нэгж, 35 иргэн, 15 автомашин шалган Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо “Сэт клуб” ХХК-ны “Сэт” бааранд 2017 оны 07 дугаар сарын 06-ны 01:35 цагт архи согтууруулах ундаагаар үйлчилсэн, мөн оны 07 дугаар сарын 07-ны өдөр Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 04-62УБҮ улсын дугаартай приус маркийн автомашинтайгаар С.Болортамир/ЕП88063010/ гар дээрээс согтууруулах ундаа худалдан борлуулсан, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Амт” супермаркет дэлгүүрт худалдагч Д.Номинзаяа нь иргэн Х.Баярмагнайд архи согтууруулах ундаа худалдан борлуулсан зөрчлийг илрүүлэн Д.Номинзаяа, С.Болортамир нараас нийт 33,5 литр архи, 11 литр пиво тус тус хураан авч Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох орон тооны бус зөвлөлд шилжүүлэн С.Болортамир, Д.Номинзаяа нарт Зөрчлийн тухай хуулинд зааснаар тус бүрийг 50000 төгрөгөөр торгож ажилласан. Нэгдсэн саатуулах байранд 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Э.Энхболд, Г.Ганзолбоо, Т.Баярхүү, 07-ны өдөр Б.Батнасан, Л.Гантөмөр нарын нийт 5 иргэн саатуулагдсан байна. Э.Энхболд, Г.Ганзолбоо, Т.Баярхүү, Б.Батнасан, Л.Гантөмөр нараас хориглосон өдрүүдэд архи согтууруулах ундаа хаанаас худалдан авч, эрүүлжүүлэх байранд саатуулагдсан шалтгааныг тогтооход Т.Баярхүү өөрийн эзэмшлийн автомашинаар “Драгон” автовокзал руу 2 иргэнийг хүргэж өгөхөд такси үйлчилгээний мөнгө хүрэхгүй, төлбөрт нь өгсөн архийг өгсөн, Э.Энхболд, Г.Ганзолбоо, Б.Батнасан, Л.Гантөмөр нар нь хориглосон өдрүүдээс өмнөх өдрүүдэд худалдан аваад гэртээ хадгалж байсан архиа, хэрэглэсэн үедээ эрүүлжүүлэгдсэнийг тогтоож ажилласан.

Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжихтэй холбоотойгоор хүчин төгөлдөр мөрдөж байгаатай холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиас суллагдах этгээдийг цагдаагийн байгууллагаас захиргааны хяналтанд авах ажлыг зохион байгуулах, судалгаанд хамруулах, дахин давтан гэмт хэрэг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдөр 08:30-03:30, 04-ний өдрийн 10:00-02:30, 05-ны өдрийн 08:30-05:00 цагийн хооронд Хан-Уул дүүрэг дэх засан хүмүүжүүлэх 431 дүгээр хорих ангид 08:30 цагаас 05:00 цагуудын хооронд ажиллаж тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт суллагдаад очих хаягтай 17, Дорнод аймагт суллагдаад очих хаягтай 15 иргэний судалгааг дэлгэрэнгүй авч, зурагжуулан, дахин гэмт хэрэгт холбогдохгүй байх, анхаарах асуудлын талаар зөвлөмжийг гардуулан өгч, суллагдсан иргэдийн аюулгүй байдлыг ханган албаны автомашинаар хэсгийн байцаагч болон цагдаагийн хэлтсийн байранд хүргэн ирж ар гэрийн хүмүүст хүн нэг бүрийг хүлээлгэн өгч хүлээн авсан иргэдийн овог нэр, регистрийн дугаар, хаяг, утасны дугаар, гарын үсгийг зуруулан ажилласан. Мөн Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт суллагдаад очих хаягтай 53 иргэний дэлгэрэнгүй судалгааг авсан. Энэхүү судалгааг тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт оршин суух хаягтай 17 иргэний судалгааны хамт дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Ганбаярт хэвлэн өгч, хэсгийн байцаагч нэг бүрийн дотоод цахим шууданд хийж ажилласан болно. Хорих ангиас суллагдан судалгаанд хамрагдсан 17 иргэний мэдээллийг Цагдаагийн байгууллагын Мэдээллийн нэгдсэн санд оруулан ажиллахыг хэсгийн байцаагч нарт даалгаж ажилласан.

Тус хэлтсээс Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 91 дүгээр тогтоолоор нийслэлийн хэмжээнд сар бүрийн 01-ний өдрийг “Архи согтууруулах ундаа худалдаалахгүй өдөр” болсонтой холбогдуулан тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор хариуцсан нутаг дэвсгэртээ “Нэгний өдөр” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж хэлтсийн №33 тоот албан мэдэгдлийг нийт 264 аж ахуйн нэгжид хүлээлгэн өгч ажилласан. Хариуцсан нутаг дэвсгэртээ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 91 дүгээр тогтоолын хэрэгжилтийг аж ахуйн нэгж байгууллагууд хэрхэн хангаж байгаа талаар хяналт шалгалтыг 10:00-17:00, 20:00-01:00 цагийн хороонд машинт эргүүлийн 4 чиглэлд 8 алба хаагч, явган эргүүлд 12 алба хаагчид зохион байгуулж Эргүүл хамгаалалт хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад Б.Найдансүрэн хяналт тавьж үүрэг чиглэл өгч ажилласан. Автомашинт эргүүлийн Хайрхан-112 чиглэлийн алба хаагчид үүрэг гүйцэтгэх хугацаандаа ЧД-ийн 3 хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сувд “ нэртэй дэлгүүр нь архи согтууруулах ундаа худалдан борлуулж байсан зөрчлийг илрүүлэн зөрчил гаргагч С.Хишигжаргалыг Зөрчлийн тухай хуулийн 6.5.13-д заасан зөрчил гаргасан үндэслэлээр хэсгийн байцаагч цагдаагийн дэслэгч Б.Түвшин-Эрдэнэ нь 50.000 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн. Массаж хэсэгчилсэн арга хэмжээг 2017 оны 08 дугаар сарын 12-наас 15 ны өдрүүдэд зохион байгуулж Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Саун”-ны үйл ажиллагаа эрхэлдэг-5, “Массаж”-ны үйл ажиллагаа эрхэлдэг нийт 9 газрыг шалгасан. Шалгалтаар: Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “life”, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сити”, 9 дүгээр хорооны нутаг дэвсгэр “Их бүрд” цогцолборт байрлах массажны газруудад “Садар самуунтай тэмцэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг талаар шалгалт хийн ажиллахад өнөөдрийн байдлаар тийм зүйл тогтоогдохгүй байна.Төв зам дагуу барилга байгууламж, гэрлийн шон дээр наасан “Массаж” гэсэн зарлалыг гэрэл зургаар баримтжуулан, садар самууныг сурталчилж, бие үнэлэхийг зохион байгуулж байгаа хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр шалгалтыг явуулж “Гулгаа

массаж”, “Массаж” гэж байршуулсан 8 зарлалаас / 80292984, 86281020, 80172042/ дугаар бүхий зарыг хуулан авч эрүүгийн цагдаагийн тасагт шалгуулахаар болсон.

Хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа, олон нийтийн цагдаа нар Чингэлтэй дүүргийн 1-3 дугаар хорооны нутаг дэвсгэрт Энхтайваны өргөн чөлөө, Төв шуудангаас Мөнгөн завьяагийн автобусны буудал, УИД, мэргэжилтэний 20-ийн автобусны буудал, Голомт картын төв, Баруун 4 зам дагуу зохих зөвшөөрөлгүй гар дээрээс худалдаа эрхэлдэг иргэдэд шинээр батлагдсан Зөрчлийн тухай хуулийн 10.4 дүгээр зүйл. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, зөвшөөрөлтэйгээр эрхлэх худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээг зөвшөөрөлгүйгээр явуулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн заалтыг баримтлан ажилласан. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, цэгт худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. /Гэсэн холбогдох заалтын мэдэгдэлд тусгаж зохих зөвшөөрөлгүй гар дээрээс худалдаа үйлчилгээ хийж байсан 37 иргэнд тайлбарлан өгч, дахин зөрчил гаргахгүй байх талаар баталгаа авч гарын үсэг зуруулан авсан. Мөн зөрчил гаргасан 23 иргэнийг хорооны хэсгийн байцаагчийн өрөөнд авч бүртгэл судалгаанд хамруулсан.

Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд 2017 оны 08 дугаар сарын 11-нд “Сэргээн шийдвэрлэлт” арга хэмжээний хүрээнд ЧД-ийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлан үйл ажиллагаа явуулдаг ломбардаар орж бүртгэл судалгааг шинэчилж 2017 оны 07 дугаар сарын 01-ээс 08 дугаар сарын 10-ны хүртэл үйлчлүүлсэн иргэдийн мэдээллийг авч шалгахад 43 сэжиг бүхий этгээдээс 10 этгээд нь удаа дараа байнга эд зүйл тавидаг, 25 сэжигтэн этгээд, 6 этгээд нь шүүхээс эрэн сурвалжилж байгаа, 2 этгээд сэтгэцийн өвчтэй, архаг архичин 1, биеэ үнэлэгч 2 олдож гэмт хэргээс урьдчилан сэргийлж ажилласан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 91 дүгээр тогтоолоор нийслэлийн хэмжээнд сар бүрийн 1-ний өдрийг “Архи согтууруулах ундаа худалдаалахгүй болгон зохион байгуулсантай холбогдуулан “Тогтоол-3” хэсэгчилсэн арга хэмжээг 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж ахлах байцаагч, хэсгийн байцаагч, машинт эргүүлийн алба хаагчид, хороо хариуцсан цагдаа нар ажилласан. Арга хэмжээний хүрээнд тус дүүргийн хариуцсан 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 87 аж ахуйн нэгж байгууллагуудад хэлтсийн даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 40 тоот албан мэдэгдлийг хүргүүлэн биелэлтэнд авто болон явган эргүүлд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид, хэлтсийн ерөнхий эргүүлүүд хяналт тавин ажилласан.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 91 дүгээр тогтоолыг зөрчиж 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр “Архи согтууруулах ундаа худалдан борлуулсан” зөрчлүүдийг илрүүлэн ажиллаа. Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Уянга” караокед бармен Г.Мөнхзаяа/рд:чп82090902/, Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Түмэн-Арвижих” ХХК-ний “Дотно” бааранд бармен Г.Булгантамир /рд:жя91020810/, Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Кюнс кроун” ХХК-ний “Crown” бааранд А.Сарантунгалаг/рд:ae95060924/ нар нь 2017 оны 09 дүгээр сарын 01-ний архи согтууруулах ундаагаар үйлчилж байсан зөрчлүүдийг эргүүлийн офицер, цагдаагийн дэслэгч Л.Түвшинжаргал илрүүлэн хэсгийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Билэгсайхан, дэслэгч Н.Дамдинсүрэн, А.Тамирлаан нар шалгаж байна.

Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс “Хичээлийн шинэ жил” нэгдсэн арга хэмжээний хүрээг 2017.08.25–аас 2017.09.20-ны өдрийг хүртэл зохион байгуулсан. Хариуцсан 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 5,

23, 24, 50, Бадмаараг ахлах сургууль, Тусгал, Тоолол, Олонлог, Атланта, Чинхур, Оюут бага сургууль, ХНХДС, СУИС, Улаанбаатар Эрдэм Оюу зэрэг их, дээд болон ерөнхий боловсролын сургуулиудад оюутан, сурагчид, насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургуулийн орчинд болон гудамж, талбай олон нийтийн газар үйлдэгдэж байгаа гэмт хэргийг бууруулах зорилгоор хэлтсийн даргын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 39 тоот “Албан мэдэгдэл”-ийг өгч, үр дүнг тооцож ажилласан. Сургуулийн орчинд 9 дүгээр сарын 1-ний өдөр сургуулийн эргүүлийг бүх сургуулиуд ажиллуулж, 7 чиглэлд 7 урамшуулалт эргүүл, 7 олон нийтийн цагдаа 07 цагаас 14 цагийн хороонд, 4 алба хаагч дугуйт эргүүлээр 09 цагаас 17 цагийн хороонд, 17 цагаас 01 цаг хүртэл 8 чиглэлд 16 алба хаагч / хэрэг бүртгэгч, мөрдөгч нар/, 4 чиглэлд 8 алба хаагч 24 цагаар авто эргүүлийн үүргийг гүйцэтгэж ажиллаа. Ерөнхий боловсролын сургууль нэг бүрээс 2017-2018 оны хичээлийн жилд ажиллах нэг бүрээс 2017-2018 оны хичээлийн жилд ажиллах “ SCHOOL POLICE” эцэг эхийн эргүүлийн хуваарийн гаргуулан авч хяналт тавьж ажиллаж байна. Мөн 9 дүгээр сарыг дуустал олон нийтийн цагдаа, урамшуулалт эргүүлийг өдөр бүр 09-16 цаг хүртэл сургуулиудын орчинд ажиллуулж байна. Оюутан, сурагчид, насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургуулийн орчинд болон гудамж, талбай олон нийтийн газар үйлдэгдэж байгаа гэмт хэргийг бууруулах зорилгоор “ Аюулгүй байдлыг хангах иргэн бүрийн үүрэг”, “ Аз жаргалтай гэр бүлийн төлөө хамтдаа” зөвлөмж, “хүчирхийллээс хүчирхийлэл төрдөг” халаасны хулгайчаас болгоомжил” зэрэг зурагт хуудас, тараах материалыг архи согтууруулан ундаагаар үйлчилдэг 87 аж ахуйн нэгж, 14 их дээд, болон ерөнхий боловсролын сургуулиудад нийт 150 ширхэгийг хүргүүлж, сургуулийн коридор, мэдээллийн самбарт байршуулж ажиллаа.

Сургууль бүрт “өсвөрийн цагдаа” бүлгэм байгуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль суртчилах үйл ажиллагааг эхлүүлэн, үйл ажиллагаанд нь хамтран арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Сургуулийн орчинд халаасны хулгай болон дээрэм, булаалт, танхай, залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хичээлийн байрны гадна, дотно хяналтын камерын тоог нэмэгдүүлж, камерын хяналтын хэвийн үйл ажиллагааг шалгах, харуул хамгаалалт хариуцсан ажилтандаа сонор сэрэмжийг дээшлүүлэх талаар зөвлөмж, зааварчилгаа өгч ажиллаа. Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтануудтай хамтран гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй эрсдэлтэй хүүхдүүдийн судалгааг гаргаж, мэдээллийг санд бүртгэж, хяналтанд авч тэдэнд мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаж байна. Хариуцсан нутаг дэвсгэртээ төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, сууц өмчлөгдийн холбоо, иргэдтэй хамтран “Эргүүл” хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шинээр хэрэгжиж буй “Зөрчлийн тухай хууль”, “эрүүгийн хууль”-ийн талаарх мэдээллийг бэлтгэн 5, 23, 24, 50, Бадмаараг ахлах сургууль, Тусгал, Тоолол, Олонлог, Атланта, Чинхур, Оюут бага сургууль, ХНХДС, СУИС, Улаанбаатар Эрдэм Оюу сургуулиудын нийт 2500 оюутан сурагчдад өгч ажиллаа. Хичээлийн шинэ жил нэгдсэн арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдад хар тамхи, мансууруулах бодисын хор уршгийн талаарх хичээлийг боловсруулах 3 минутын “Мансууралтай тэмцье” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Мөн сургууль бүрийн facebook хуудсанд Цагдаагийн Ерөнхий газрын урьдчилан сэргийлэх хэлтсээс гаргасан “Мансуурлын эсрэг хамтдаа тэмцье” шторкуудыг байрлуулж мэдээллийг хүргэсэн.

Зөрчлийн тухай хуулийн 6.3 /Тамхины хяналтын тухай хууль зөрчих/ дугаар зүйл, 6.5 /Худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих/ дугаар зүйлийн хэрэгжилт хангалтгүй байгаатай холбогдуулан зөрчлийн илэрүүлэлтийг эрчимжүүлэх, согтуугаар үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гудамж талбай

олон нийтийн газарт тамхи татах, зохих зөвшөөрөлгүй худалдаа наймаа хийх зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариуцлага тооцох зорилгоор 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс 23-ны хүртэл Эрчимжүүлэлт-2 нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан.

Зөрчлийн тухай хуулийн 6.3 /Тамхины хяналтийн тухай хууль зөрчих/ дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 8 зөрчлийг илрүүлэн шалгасан. Зөрчлийн тухай хуулийн 6.5 / архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих/ дугаар зүйлийг хэрэгжлүүлэх чиглэлээр Чингэлтэй дүүргийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчилдэг 250 аж, ахуй нэгж байгууллагад хяналт шалгалтыг явуулж дараах зөрчлийг илрүүлэн ажиллаа. Үүнд: Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо Крон паб архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсныг хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад Отгонзаяа материалжуулан шалгаж Зөрчлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлийн 13 дэх хэсэгт зааснаар арга хэмжээ авсан. Зөрчлийн тухай хуулийн 10.4/ худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих/ дугаар зүйлийг хэрэгжүүлэх чиглэлээр: Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо “Дотно” караоке архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсныг эргүүлийн офицер, цагдаагийн ахлах дэслэгч Д.Лхагвасүрэн илрүүлж хэсгийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Түвшинэрдэнэ материалжуулан тус тус шалгаж байна. Арга хэмжээний хүрээнд зөвшөөрөлгүйгээр гар дээрээс тамхи худалдан борлуулсан 10 зөрчлийг илрүүлэн шалгаж хураагдсан 85 хайрцаг, 150 ширхэг тамхийг Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох орон тооны бус зөвлөлд шилжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 410 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 2017 оны 09 дүгээр сарын 01-04-ний өдрүүдэд “Цахим тоглоом” нэгдсэн арга хэмжээ явагдаж, хариуцсан 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “TG”, “RED”, “MIKII”, “PLAY MANIA”, “GOTO”, “UB NET”, “ANGEL-1”, “LEGEND”, “EGUS”, “NUB ESPOTRT”, “E-SPORT BONE”, “PHOENIX GAME”, “THE LOF-3”, “NEW FORCE”, “GOOD LUCK CLUB”, “LIDER”, “DOTO HAUS” зэрэг 17 интернет, цахим тоглоомын газраар хяналт шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтын явцад цахим тоглоомын үйлчилгээний бүртгэлийн гэрчилгээг холбогдох эрүүл ахуй, ажлын байрны нөхцөл, галын аюулгүй байдлын дүгнэлт зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан 5, цаг хэтрүүлж ажилласан 2, Зөвшөөрөлтэй боловч хориглосон газар буюу орон сууцны нэг давхар, хонгилд үйл ажиллагаа явуулдаг 4 зөрчлийг илрүүлэн шалгасан. Зөрчил заагдсан дээрх цахим тоглоомын газруудад Хэлтсийн даргын 41,42 тоот “Албан мэдэгдэл” өгч, үр дүнг тооцож ажиллаа. Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйд тохируулан цахим орчинд хэрхэн зөв ажиллах талаар мэдлэг олгох, учирч болох болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цахим гэмт хэргийн нөлөө, түүний үр дагавар, амьдралын зөв дадал, олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Цахим орчин дахь гэмт хэрэг” сэдэвт сургалтыг 2 дугаар хорооны хамтарсан багтай хамтран 23 дугаар сургуулийн 9 дүгээр ангийн 60 сурагчдад зохион байгууллаа. Уг сургалтыг УЕПГ-ын сургалт судалгааны төвийн хяналтын прокурор кримнологич Г.Оюунболд, “Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн”-гийн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Г.Билгүүн, Сургалт хариуцсан мэргэжилтэн В.Оюун-Эрдэнэ удирдан явууллаа.

Монгол улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6, “Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын (код 605) Гэрээт хувийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх, гэрчилгээ олгох, хяналт тавих, бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан журмын хэрэгжилтийг шалган, илэрсэн зөрчлийг арилгуулах, бүртгэлгүйгээр

хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийг олж тогтоох, хариуцлага тооцох, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах зорилгоор 2017 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байна.

Монгол улсын цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д “Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын /код 605/, Гэрээт хувийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх, гэрчилгээ олгох, хяналт тавих, бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан журмын хэрэгжилтийг шалган, илэрсэн зөрчлийг арилгуулах, бүртгэлгүйгээр хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийг олж тогтоох, хариуцлага тооцох, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах зорилгоор Чингэлтэй дүүргийн 1-9 хорооны нутаг дэвсгэрт гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг шалгах ажлын салбар төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна.

Тус цагдаагийн хэлстийн хариуцсан нутаг дэвсгэрт гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэж буй 37 аж ахуйн нэгж байгууллагын судалгааг хороо тус бүрээр гарган, Цагдаагийн ерөнхий газрын 2008 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 126 тоот тушаалаар батлагдсан Харуул хамгаалалтын байгууллагын алба хаагчдын ялгах тэмдэг, дүрэмт хувцас өмсөж хэрэглэх журам, тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журмуудыг хэсгийн байцаагч нар хувилан өгч Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Р.Төмөрбаатар Мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй эсэх зэрэг хяналт шалгалтыг 12 чиглэлээр хийж гүйцэтгэх, мөн зөвшөөрөлгүйгээр гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг илрүүлэх талаар мэргэжлийн удирдлага, ажиллах нөхцөл бололцоогоор ханган ажиллаж байна.

“Илрүүлэлт-Оргодол” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус цагдаагийн хэлтэст шүүхээс иргэний хариуцагчийн оршин суугаа хаягийг олж тогтоохыг даалгасан захирамж шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх зорилготой “Шүүхийн шийдвэр” хэсэгчилсэн арга хэмжээг 2017 оны 10 дугаар сарын 13-наас 11 дүгээр сарын 06-ны өдөр хүртэл зохион байгуулж байна.

Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс “Хууль бидний амьдралд” сэдэвт аяныг 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн хариуцсан 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Бадмаараг” ахлах сургууль, 5, 23, 24, 50, Тусгал, Тоолол, Олонлог, Атланта, Чинхур, Вэтүв сургуулиудад тус тус 14 хоног зохион байгуулах хуваарь гарган ажиллаж байна. “Хууль бидний амьдралд” сэдэвт өдөрлөгийг СУИС-ийн харьяа “Бадмаараг” ахлах сургуулиас 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр эхлэн зохион байгуулж аяны нээлтийг СУИС-ын “Оюутан театрт” 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 09:00-11:30 цагийн хооронд зохион байгуулсан. Нээлтэнд Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын орлогч, Боловсролын хэлтсийн дарга Байгальмаа, 5, 23, 24, 50, Тусгал, Тоолол, Олонлог, Атланта, Чинхур, Вэтүв сургуулиудын захирал, нийгмийн ажилтан нар, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээч, цагдаагийн ахлах дэслэгч М.Түмэннаст, НЦГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Даариймаа, тус хэлтсийн нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Р.Төмөрбаатар, ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Ю.Баяр-Эрдэнэ, Д.Оюунчимэг нар оролцсон. Өдөрлөгт “Бадмаараг” ахлах сургуулийн сурагчид Монгол улсын Үндсэн хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэнд тавих тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулиудаар гар зургийн уралдаан зохион байгуулан “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-аар тэргүүн

байр эзэлсэн 12в ангийн хамт олонд тус цагдаагийн хэлтсийн “Баярын бичиг”, мөнгөн шагналаар шагнагдсан. Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Оюунчимэг “Гэмт хэрэг урьдчилан сэргийлэхэд хүүхэд бидний оролцоо” сэдвээр, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээч, цагдаагийн ахлах дэслэгч М.Түмэннаст “Криминалистикийн тухай”, Бадмаараг сургуулийн эмч Б.Батчимэг “Эмнэлгийн анхан шатны тусламж хэрхэн үзүүлэх талаар сурагчид жүжигчилсэн тоглолт үзүүлэн илтгэл хийсэн. Мөн Бадмаараг ахлах сургуулийн драм, жүжиг, бүжгийн ангийн сурагчид урлагийн тоглолт хийн, Дүрслэх урлагийн ангийн сурагчид зургийн бүтээлээр үзэсгэлэн гаргаж оролцсон. Аяны хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах “Хууль бидний амьдралд” аяны хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тэмдэглэл хөтлөх дэвтэр нээж Бадмаараг сургуулийн захирал М.Энхчимэгт гардуулан өгч ажилласан. Өдөрлөгийн ажиллагааны талаар тус цагдаагийн хэлтсийн Facebook хуудсаар, Монголын үндэсний телевизээр сурталчилж, арга хэмжээг газар дээрээс нүүр хуудсаар дамжуулан “Live” хийн сурталчилсан.

Эрүүгийн хууль/шинэчилсэн найруулга/ 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжсэнтэй холбоотойгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиас суллагдсан тус хэлтсийн хариуцсан 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт оршин суух хаягтай 17 этгээдийг дахин гэмт хэрэгт холбогдохгүй байх баталгаа бичүүлэн ажиллаж байна. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжсэнтэй холбоотойгоор тус цагдаагийн хэлтэст Шүүхээс болон хорих ангиудаас тэнсэн суллагдсан 51 иргэний ялыг өөрчлүүлэхээр 2017 оны 07 дугаар сард ЧДПГ-т хүргүүлсэн боловч 2002 оны Эрүүгийн хуулиар хорих ял оногдуулж уг ялыг тэнссэн, хорих ялаас хугацааны өмнө тэнссэн, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан ятнуудын ялыг 2015 оны Эрүүгийн хуулийг дагаж мөрлөх журмын тухай хуульд дүйцүүлэн хасах талаар тухайлан зохицуулаагүй гэх үндэслэлээр шүүхээс ялтны ялыг шийдвэрлээгүй прокурорт буцаан ирүүлсэн тул захиргааны хяналт тавьж байсан үндэслэл, журмын дагуу ялын биелэлтэнд үргэлжлүүлэн хяналт тавьж дуусган, Шүүхээс шинээр хорих ял оногдуулахгүй тэнссэн ялтанд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас хяналт тавьж ажиллах чиглэлийг прокуророос өгсний дагуу захиргааны хяналтыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Тус цагдаагийн хэлтэст хорих ангиас хугацааны өмнө тэнсэн суллагдсан, шүүхээс хорих ялыг тэнссэн, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан нийт 50 ялтан захиргааны хяналтанд байна. Үүнээс: хорих ангиас хугацааны өмнө тэнсэн суллагдсан 10 ялтан, шүүхээс тэнсэгдсэн 35 ялтан, ял хойшлогдсон 5 ялтан/бага насны хүүхэдтэй 3, насанд хүрээгүй 2/ байна.

Чингэлтэй дүүрэг үүсч байгуулагдсаны 25 жилийн ойн арга хэмжээний хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хангуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хангах үүрэг бүхий баг, сайн дурын иргэд идэвхтнүүдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, энэ талын мэдлэг, ур чадварыг сорих, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлье” сэдэвт Чингэлтэй дүүргийн 1-19 дүгээр хороодын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх баг, хэв журмын урамшилт эргүүл, гудамж байрны нийтийн эргүүлийн нэгдсэн сургалтыг Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын тамгын газартай хамтран 2017 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Олон улсын хүүхдийн Найрамдал хүүхдийн төвийн Хараацай театрт зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудаар “Дэвжээ”, “АХА” тэмцээнийг зохион байгуулсан. Дэвжээ тэмцээнд 7 дугаар хорооны Гэмт хэргээс

урьдчилан хамтарсан баг 1 дүгээр байр эзэлж, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.

СУИС-ийн 1 дүгээр курсын 97 гадаад оюутанд/гадаад орнуудаас суралцаж байгаа/ оюутнуудад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Хууль сурталчлах өдөрлөг”-ийг 2017.09.29-ны өдрийн 14-16 цагийн хооронд Гэрбүл, хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Оюунчимэг, хороо хариуцсан цагдаа, цагдаагийн дэд ахлагч С.Дашням нар гадаад хэл дээр зохион байгуулсан талаар тус хэлтсийн Facebook хуудсанд байршуулан ажилласан. Хэлтсийн хариуцсан 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шалтгаан нөхцөл, цаг улирлын давтамжийг тогтоох зорилгоор криминологи баг долоо хоног бүрийн мягмар гарагт хуралдаж, ажлын чиглэлийг тодорхойлон цаашид хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж хэвшсэн. Хэлтсийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг захиргааны зөрчлийг 7 хоногоор “Google map” программд шивж оруулан зураглал гаргаж гэмт хэрэг зөрчлийг дахин гарахаас урьдчилан сэргийлж, эргүүлийг зөв оновчтой зохион байгуулж ажиллаж байна.

Тус цагдаагийн хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд дээрмийн гэмт хэрэгт ихээр өртөж байгаатай холбогдуулан дээрмийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ерөнхий боловсролын 23, 24, 50 дугаар сургуулийн 4-7 дугаар ангийн сурагчдад санамж зөвлөмж, сэрэмжлүүлэг өгч, дээрмийн гэмт хэргийг бууруулахад зорилгоор 2017 оны 10 дугаар сарын 20, 23, 25-ны өдрүүдэд сургалт зохион байгуулсан. Арга хэмжээнд хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа, олон нийтийн цагдаа, ахлах байцаагч, ахлах мэргэжилтэн нар оролцож ерөнхий боловсролын 23, 24, 5, 50 дугаар сургуулийн 4-7 дугаар ангийн нийт 72 бүлгийн анги тус бүрт зохион байгуулж дээрмийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар боловсруулж өнгөт хуудсаар хэвлэсэн зөвлөмжийг анги бүрийн “Ангийн булан”-д 72 ширхгийг байршуулсан. Сургалтанд нийт 2870 сурагчид хамрагдсан. Мөн урамшилт эргүүл, нийтийн эргүүлийн талаар 2017.10.23-ны өдөр Монгол НД телевизийн Өглөө хөтөлбөрөөр, Эргүүлийн талаар TV-5 телевизээр 2017.10.09-ний өдөр, Илрүүлэлт Оргодол арга хэмжээний хүрээнд тус цагдаагийн хэлтэст ХСИС-ийн оюутан дээрмийн гэмт хэргийг илрүүлэн ажилласан талаар ЦЕГ-ын Дуудлага студийн “Амрыг эрье” нэвтрүүлгээр 2017.10.10-ны өдөр, ГХУС чиглэлээр хамтарсан баг, урамшилт эргүүл, нийтийн эргүүл, гудамж байрны нийтийн эргүүлийн нэгдсэн сургалтын талаар хэлтсийн Facebook хуудсаар, Гэр бүл хүүхэд хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Оюунчимэг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар MGL 102.1 радиогийн 40 минутын шууд ярилцлага өгсөн.

Гар утас хэрэглэгч иргэдэд 2017.10.03-ны өдөр 119 ширхэг, Хулгайн гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 50 ширхэг зөвлөмжийг тус тус тарааж ажилласан. Тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчилдэг 294 аж ахуйн нэгж байгууллагын тусгай зөвшөөрлийг 2017.10.06-09-ний өдрүүдэд шалган ажилласан. Ерөнхий боловсролын 5, 23, 24, 50, Бадмаараг ахлах сургууль, Тусгал, Тоолол, Олонлог, Атланта, Чинхур, Оюут бага сургуулиудад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэлтсийн даргын 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 52 тоот албан мэдэгдлийг хүргүүлэн ажиллаж байна. ” шторкуудыг байрлуулж мэдээллийг хүргэсэн.

“Тэнэмэл” Нэгдсэн арга хэмжээний хүрээнд. Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржаваас 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн “Нэгдсэн ажиллагаа зохион байгуулах тухай” А/225 дугаар тушаалын дагуу тус цагдаагийн хэлтсээс хариуцсан 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт гэр оронгүй тэнэмэл

иргэд болон хараа хяналтгүй хүүхдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж, бүртгэлжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж, зөвлөгөө өгөх, Гэр бүл хамгаалах төвд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах, цагдаагийн хэлтсийн алба хаагчдын нэгдсэн ажиллагааны чадварыг үнэлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулж ажиллаа. Үүнд:

Тус цагдаагийн хэлтсээс 30 алба хаагч, Цагдаагийн ерөнхий газраас 5 хаагч, Эрүүгийн цагдаагийн албанаас 1 хаагч, Мөрдөн байцаах албанаас 1 алба хаагч, Нийслэлийн цагдаагийн газраас 5 алба хаагч, Мэдээлэл шуурхай удирдлагын төвөөс 5 алба хаагч, Хамгаалалтын газраас 20 алба хаагч нийт 67 алба хаагч оролцсон. Бэлтгэл ажлын хүрээнд алба хаагчдын ирц бүртгэн, хувцаслалт, бичиг баримтад үзлэг шалгалт хийн Цагдаагийн ерөнхий газрын тушаал, Гэр оронгүй, тэнэмэл иргэд болон хараа хяналтгүй хүүхдийг бүртгэлжүүлэх нэгдсэн ажиллагааны төлөвлөгөөг танилцуулж, алба хаагчдыг нэр заан томилгоожуулж, ажил үүргийн хуваарь чиглэлийг өгч мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Нэгдсэн ажиллагаанд шаардагдах автомашин, шатахуун, бичгийн цаас, маск, бээлий гэх мэт техник, бусад хэрэгсэлийн бэлэн байдлыг Захиргааны удирдлагын тасгаас бэлтгэн, ажиллагааны явц байдлын талаарх дүн мэдээг цаг тутам нэгтгэж, Нийслэлийн цагдаагийн газар, /Шонхор/ Дөл, нарт хүргүүлсэн.

Тус хэлтэст бүртгэгдсэн эрэгтэй 32, эмэгтэй 4, хүүхэд 1-ийн мэдээллийг Цагдаагийн байгууллагын бүртгэл, мэдээллийн санд шивж оруулан, зурагжуулж, гарын хээг папилон санд авахуулж, эрэн сурвалжлах ASAP санд тулгалт хийж ажилласан. Хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт байнга архи дан согтуурдаг 7 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулахаар материалжуулан Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд үзлэгт оруулахаар бэлтгэж, мөн 5 иргэнийг ар гэрт нь хүлээлгэн өгсөн.

Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо Цэцэг төвийн автобусны буудал орчим тэнүүчилдэг Н.Мөнгөлдэй /9 нас, эр/-г Баянзүрх дүүрэгт байрлах хүүхэд халамжийн төвд хүргүүлсэн.

Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, Чингэлтэй дүүргийн Гэр бүл хүүхэд хөгжлийн хэлтэс, “Шинэ амьдрал ялагч” ТББ, “Хан богд” ТББ зэрэг хамтран ажилласан. Тус хэлтсээс ажиллагааны хүрээнд Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд 7 иргэн, Шинэ амьдрал ялагч” ТББ-д 3 иргэн, “Хан богд” ТББ 4 иргэнийг тус тус аюулгүй байдлыг нь ханган харгалзан хүргэж өгсөн.

“Илрүүлэлт-Оргодол” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус цагдаагийн хэлтэст шүүхээс иргэний хариуцагчийн оршин суугаа хаягийг олж тогтоохыг даалгасан захирамж шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх зорилготой “Шүүхийн шийдвэр” хэсэгчилсэн арга хэмжээг 2017 оны 10 дугаар сарын 13-наас 11 дүгээр сарын 06-ны өдөр хүртэл зохион байгуулж байна.

“Хяналт-2” нэгдсэн арга хэмжээний салбар төлөвлөгөөг боловсруулж 2017 оны 10 дугаар сарын 25 –ны өдөр хэлтсийн даргаар батлуулж алба хаагчдад хүлээлгэн өгсөн. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж хариуцсан хороодын нутаг дэвсгэрт эргүүл шалгалтыг зохион байгуулж Чингэлтэй дүүргийн 6 дуугаар хороо 63 дугаар байрны 1 давхарт зөвшөөрөлгүй тамхи худалдан борлуулсан Б.Батнасан гэгчийг Зөрчлийн тухай хуулийн 6.3.2-т зааснаар 300.000 төгрөгөөр, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо Сентури рестораны VIP өрөөнд Г.Уранцэцэг гэгч нь утаат тамхи татсан гэх зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 6.3.1-т зааснаар 50.000 төгрөгөөр, Чингэлтэй дүүргийн 4 хороо СУИС-ийн дотуур байранд Хятад улсын иргэн Ц.Еснин гэгч нь утаат тамхи татсан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 6.3.1-т зааснаар 50.000 төгрөгөөр тус тус арга хэмжээ тооцсон. Мөн Зөрчлийн тухай хуулийн 5.1.1-т

зааснаар 40 иргэнийг 400.000 төгрөгөөр торгож шийтгэл ногдуулсан. Чингэлтэй дүүргийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хүнсний дэлгүүр, зах бөөний худалдааны төвүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулж Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа “Амт” хүнсний дэлгүүр нь 2017 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр зохих зөвшөөрөлгүй утаат тамхи худалдан борлуулж байсан зөрчлийг илрүүлэн хэсгийн байцаагч цагдаагийн ахлах дэслэгч Б.Лхамсүрэн материалжуулан шалгаж байна. Арга хэмжээний хүрээнд тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт утаат тамхи худалдан борлуулдаг нийт 68 аж ахуйн нэгж байгууллагад дүүргийн үйлдвэр үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэний хамт хяналт шалгалт зохион байгуулж, хуулийн хэрэгжил Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйл “Тамхины хяналтын тухай хууль зөрчих” Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4 дэх заалтуудын хэрэгжилтийн хүрээнд 2 зөрчлийг илрүүлэн иргэн Б.Батнасанг Зөрчлийн тухай хуулийн 6.3-т зааснаар 300.000 төгрөгөөр, “Амт” хүнсний дэлгүүрт арга хэмжээ тооцохоор материалжуулан шалгаж байна.тэнд хяналт тавьж ажилласан. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр утаат тамхи худалдан борлуулдаг 68 аж ахуй нэгж болон нийт 46 төрийн болон төрийн бус байгууллагад утаат тамхины хор уршгийн талаар 120 зөвлөмж, санамж сэрэмжлүүлэгийг хүргүүлж ажилласан.

Тус цагдаагийн хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Тамхины хяналтын тухай хууль, хор холбогдлыг таниулах зорилгоор ерөнхий боловсролын 23, 24, 50 дугаар сургуулийн 4-7 дугаар ангийн сурагчдад санамж зөвлөмж, сэрэмжлүүлэг өгч, дээрмийн гэмт хэргийг бууруулахад зорилгоор 2017 оны 10 дугаар сарын 20, 23, 25-ны өдрүүдэд сургалт зохион байгуулсан. Арга хэмжээнд хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа, олон нийтийн цагдаа, ахлах байцаагч, ахлах мэргэжилтэн нар оролцож ерөнхий боловсролын 23, 24, 5, 50 дугаар сургуулийн 4-7 дугаар ангийн нийт 72 бүлгийн анги тус бүрт зохион байгуулж дээрмийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар боловсруулж өнгөт хуудсаар хэвлэсэн зөвлөмжийг анги бүрийн “Ангийн булан”-д 72 ширхгийг байршуулсан. Сургалтанд нийт 2870 сурагчид хамрагдсан. Тус хэлтсийн 4 дүгээр хорооны хэсгийн байцаагч, хороон цагдаа нар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ЕБ-ийн 5 дугаар сургууль, Бадмаараг лицей сургууль, Улаанбаатар Эрдэм, Шинэ иргэншил дээд сургуулийн захирал нийгмийн ажилтан нартай уулзаж сургууль орчим “Тамхигүй орчин” бий болгох талаар хамтран хууль сурталчилж ажилласан.

“Шүүхийн шийдвэрлэлт” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэмжээнд шүүхээс эрэн сурвалжлахаар даалгасан 321 материалыг 60 алба хаагчдад 1 сарын хугацаатай тараан өгч, биелэлт үр дүнг тооцон ажилласан. Ажиллах хугацаанд шүүхээс даалгасан 41 иргэнийг олж тогтоон шүүхийн эрэн сурвалжлалтыг зогсоон, 19 иргэнийг Монгол улсын хилээр гарсаныг тогтоосон байна.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өлдрийн “Ажлын хэсэг байгуулж, хяналт шалгалт хийх тухай” А/202 дугаар тушаал гарсантай холбогдуулан тус цагдаагийн хэлтсийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт худалдаа, хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг 13 газарт Чингэлтэй дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Д.Булган, мэргэжилтэн С.Намуунзаяа, мөн дүүргийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга Б.Ганчимэг, цагдаагийн ахлах дэслэгч Д.Лхагвадулам нар 2017 оны 11 дүгээр сарын 21, 23-ны өдрүүдэд хяналт, шалгалт зохион байгуулж ажилласан. Шалгалтаар хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд гэмт хэргээс урьдчилан сэргийлж чиглэлээр санамж, сэрэмжлүүлэг бэлтгэж нүдэнд ил

харагдах хэсэгт байрлуулсан эсэх, хяналтын камертай, камер нь шаардлага хангасан түвшинд харагдах орчин хангалттай болон хадгалах хугацаа, мөн харуул хамгаалалт, дохиолол хамгаалалт, галын аюулгүй байдлын чиглэлээр шалган зааварчилсан.

Тус хэлтсийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байгууллага аж ахуйн нэгж, иргэдийн гудамж талбай, олон нийтийн газар байршуулсан камерын хяналтын хэвийн ажиллагаатай эсэхийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой “Камержуулалт” хэсэгчилсэн арга хэмжээг 2017 оны 11 дүгээр сарын 17-19 –ний өдрүүдэд 16-22 цагийн хооронд зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд алба хаагчдыг 3 бүст хувааж, хороо тус бүрээр ахлах байцаагч нарт хариуцуулан өгч үр дүнг илтгэх хуудсаар тооцож ажилласан. Арга хэмжээний хүрээнд нийт 8 ахлах байцаагч 78 алба хаагчийг хариуцан ажилласан. “Камержуулалт” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг нийт 643 аж ахуйн нэгж байгууллагаар шалгалт хийж хяналтын камертай эсэх, камертай бол чанарын шаардлага хангаж байгаа эсэх талаар хяналт шалгалтыг явуулахад дараахь зөрчлүүд илэрлээ. Үүнд Камерын зөрчилтэй стандартын шаардлага хангахгүй 102 аж ахуй, огт камергүй 53 аж ахуйн нэгж байгууллагыг илрүүлсэн.

“Зэвсэг-2017” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2017 оны 10 дугаар 26 өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хооронд дүүргийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг иргэд, аж ахуй нэгж байгууллагад бүртгэлтэй байгаа галт зэвсгийг биечлэн тоолохдоо нүд үзэж, гол төмөр, замагны дуцгаарыг фото зургаар баримтжуулан авч галт зэвсгийн нэгдсэн сангийн бүртгэлд оруулж байгаа бөгөөд, одоогийн байдлаар 962 галт зэвсэг бүртгэхээс, 481 галт зэвсэг бүртгэн, 17 ширхэг галт зэвсэг харьяаллаар шилжүүлж шинээр 1 галт зэвсэг бүртгэж ажилласан. Одоо галт зэвсгийн бүртгэл 51 %- тай явагдаж байна. Арга хэмжээний хүрээнд хороо хариуцсан хэсгийн байцагч, хороо хариуцсан цагдаа, авто эргүүлийн алба хаагч нар, хэрэг бүртгэгч, мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарыг хороодод хувиарлан иргэд аж ахуй нэгж байгууллагын хаягаар явуулж, галт зэвсгийн дүнг өдөр бүр хэлэлцэж цаашид хийх ажлыг тодорхойлон ажиллаж байна. Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга галт зэвсэг хариуцсан ахлах байцаагч нарт Галт зэвсгийн тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг хангах сургалтад 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс 18 –ны өдрүүдэд Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын нэгдсэн төвд сургалтад сууж байгаатай холбоотойгоор галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бүртгэх, санд оруулах ажилд 1 алба хаагчийг татан оролцуулан зохион байгуулалтын арга хэмжээ авч, галт зэвсгийн тооллогыг эрчимжүүлэн ажиллаж байна.

Дүүргийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт бүртгэлтэй боловч тооллогод хамрагдаагүй галт зэвсгийн судалгааг гарган эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, хэрэг бүртгэгч нарыг нэг баг болгон хувиарлан өгч /ASAP санд бүртгэлтэй/ эрэн сурвалжлагдаж байгаа галт зэвсэгтэй танилцаж эрэн сурвалжлах үүрэг чиглэл өгч үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байгаа болно.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр зохион байгуулсан ажил.

Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд 2017 онд нийт 15385 хүлээн авсан дуудлага мэдээлэл, үүнээс архидан согтуурахтай холбоотой дуудлага мэдээлэл 5258 бүртгэгдсэн байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 17-ны 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 2017 оны 01 дүгээр сарын 17-20 ны өдрийг дуустал хугацаанд тус цагдаагийн хэлтсээс ажлын төлөвлөгөөг гарган биелэлт үр дүнг тооцон ажиллаа. Тус хэлтсийн хариуцсан 1-9 хорооны нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчилдэг үйлчилгээний нийт байгууллага байгаагаас бөөний төв 5, хүнсний дэлгүүр 128, рестарон кафе 157, баар 26, караоке 42 үйл

ажиллагаа явуулж байсан. Тус цагдаагийн хэлтсээс 2017 оны 01 дүгээр сарын 17-20 ны өдрүүдэд хороо хариуцсан хэсгийн байцаагч, хороон цагдаа, авто эргүүлийн цагдаа давхардсан тоогоор 148 алба хаагч, 20 автомашин, 764 удаа хяналт шалгалт хийж ажилласан. Мөн Улаанбаатар хотын цагдаагийн газраас давхардсан тоогоор 20 алба хаагч энгийн хувцастайгаар нууц далд аргаар архи согтууруулах ундаа худалдан борлуулж буй эсэхэд хяналт шалгалт хийж дүүргийн мэргэжлийн хяналтын албанаас 27 улсын байцаагч тус цагдаагийн хэлтсийн алба хаагчидтай хамтран ажиллаж Мөнхжин-Од ХХКны үйлдвэрлэсэн 196 шил “Найрсаг” нэртэй архийг хураан авч, 402 шил “Gold Chingess” архийг бүтүүмжилж ажиллаа. Нийт 4 зөрчилд 500.000 төгрөгний торгууль ногдуулан, эд мөрийн баримтаар хураагдсан Соёрхол архи 05 литр 13 шил, Нийслэл пиво 2,5 литр 8 сав, Боргио 2,5 литр 21 сав согтууруулах ундааг дүүргийн “Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох орон тооны бус зөвлөл”-д 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр 12п-5/384, 441, 442 албан тоотуудаар шилжүүлэн ажилласан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчдын 19 тоот тогтоолоор Нийслэл хотод архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилэхийг хориглосон үед архидан согтуурсаны улмаас зөрчил гаргасан 6 хүнийг эрүүлжүүлсэнээс 4 хүнд 55.000 төгрөгний торгууль ногдуулан, 2 хүнийг шүүхээр баривчлуулан ажилласан. Арга хэмжээний хүрээнд нийт 8 зөрчилд 555.000 төгрөгний торгууль ногдуулан 2 хүнийг шүүхээр баривчлуулан, 196 шил буюу 120 литр 250 грамм “Найрсаг” архийг дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэст хүлээлгэн өгсөн.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн “Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/452 дугаар захирамжаар Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн санал авах болон техникийн тооллого хийх өдөр буюу 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 00:00 цагаас мөн сарын 28-ны өдрийн 00:00 цаг хүртэл нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр зогсоож, биелэлтэнд нь хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон шийдвэр гарсантай холбогдуулан “Сонгууль” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан. Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны даргаас Нийслэлийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн “Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/452 дугаартай захирамж, хэлтсийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 28 тоот албан мэдэгдлийг тус дүүргийн нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчилдэг нийт 352 аж ахуйн нэгжид тараасан. Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагч, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нарын хамт тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчилдэг 107 аж ахуйн нэгж, 35 иргэн, 27 автомашин шалган Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо “Матрикс” ХХК-ний FACE баар нь 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 02:45 цагт шалгахад менежер Б.Ууганбаяр нь архи согтууруулах ундаагаар үйлчилсэн зөрчлийг илрүүлэн АСТТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.5 дах хэсэгт зааснаар 200.000 төгрөгний шийтгэл оногдуулан Мэдээллийн нэгдсэн сан”-д оруулан архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг НЦГ-т хүргүүлсэн.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар 2017 оны 07 дугаар сарын 01 нээс өмнө 21 иргэн, 9 аж ахуйн нэгжийг 2810000 төгрөгөөр, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар байнга архидан согтуурч орчиндоо түгшүүр төрүүлдэг 1023 иргэнийг 5115000 төгрөгний торгуулийн хуудсаар, 218 иргэнийг 1978000 төгрөгний шийтгэврээр торгож, 44 иргэнийг баривчлах, ЗХТХийн 22 дугаар зүйлд зааснаар 71 иргэнийг, 221-д зааснаар 88 иргэнийг 7-30 хоногоор баривчлуулж, 302 дах хэсэгт зааснаар 692 иргэнийг 3460000 төгрөгний торгуулийн тасалбараар, 77 иргэнийг 1125000 төгрөгний шийтгэврээр, 45 иргэнийг 7-30 хоногоор баривчлах, 32 дугаар зүйлд зааснаар 10 иргэнийг 80000 төгрөгний шийтгэврээр, 36 дугаар зүйлд

зааснаар 45 иргэнийг 225000 төгрөгний торгуулийн хуудсаар, 14 иргэн 191000 төгрөгний шийтгэврээр, ЗХТХ ийн 42 дугаар зүйлд зааснаар 28215000 төгрөгний торгуулийн хуудсаар, 48 иргэн, 1 аж ахуйн нэгж байгууллагыг 985000 төгрөгний шийтгэврээр, нийт 255 иргэнийг 7-30 хоногоор баривчлуулан, бусад зүйл хэсгээр 87 зөрчилд 687000 төгрөгөөр тус тус торгож арга хэмжээ авсан. Архины албадан эмчилгээнд 26 иргэнийг хамруулж ажилласан бөгөөд 2017 оны 07 дугаар сарын 01 – ны өдрөөс хэрэгжиж эхэлснээс хойш Зөрчлийн тухай хуулийн 6.5.11.5- д зааснаар 1 аж ахуйн нэг байгууллагыг 200.000 төгрөгөөр, 6.5.13-т зааснаар 2 аж ахуйн нэгж байгууллагыг 550.000 төгрөгөөр тус тус торгож , архидан согтуурч ар гэртэй агсам тавьж, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг нийт 4 иргэнийг Зөрчлийн хуулийн 5.4.4.1-т зааснаар 7-30 хоног баривчилж арга хэмжээ тооцсон.

Тус цагдаагийн хэлтэс нь Гэр бүл-Баяр хөөр Төрийн бус байгууллагатай хамтарч хэлтсийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт оршин суух иргэдийн дунд архидалт донтолтын эсрэг сурталчилгаа, сургалт зохион байгуулах ажилд иргэдийн оролцоог хангах, түүнчлэн архинаас үүдэлтэй хор уршгийг арилгах, Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, иргэний нийгмийн төлөөллийн санал санаачлагыг дэмжих зорилготой 1x1 хөтөлбөрийг зохион байгуулж 2 талын хамтран ажиллах гэрээг 2017 оны 04 дүгээр сарын 03 ны өдөр байгуулсан.

Хөтөлбөрийн нээлтийн ажиллагааг 2017 оны 04 дүгээр сарын 06 ны өдөр тус хэлтсийн хурлын танхимд зохион байгуулж нийт 31 иргэнийг хамруулж тус хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Р.Төмөрбаатар, ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ж.Чулуунбаяр, болон дэд хэсгийн ахлах байцаагч, хэсгийн байцаагч, хороон цагдаа нар оролцсон.

Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Р.Төмөрбаатар нь хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааг нээж үг хэлж, тус Төрийн бус байгууллагын тэргүүн Ж.Буянтөгс, менежер Э.Наранчимэг нар хөтөлбөрийн зорилго байгууллагын үйл ажиллагааг танилцуулсан.

Хөтөлбөрийн хүрээнд архины шууд болон дам хамааралтай иргэдэд архины нөлөөллөөс болсон зүрх сэтгэлийн шарх, цөхрөл, муу зуршлаасаа салах алхамууд арга замуудыг зааж өгч, хамтдаа нөхөрлөн эрүүл орчныг бүрдүүлэх ажлыг хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулж, хөтөлбөрийн гол зарчим болох 1x1 бөгөөд нэг архины хамааралтай иргэнд нэг халамжлан дэмжигч байж сургалтанд хамруулахад дэмжиж ажилласан. Сургалт нь тус төвийн сургалтын танхимд Даваа, Пүрэв гаригийн 18 цагт, Бямба гаригийн 12 цагт зохион байгуулагдсан бөгөөд тус хэлтсийн 2 хорооноос 3, 4 хорооноос 2, 5 хорооноос 2, 6 хорооноос 3, 7 хорооноос 3, 8 хорооноос 2, 9 хорооноос 3 нийт 18 иргэн хамрагдсан.

Хороо хариуцсан хэсгийн байцаагч, хороон цагдаа нар нь хариуцсан хороодын иргэдийг сургалтан бүрэн хамруулах, ирц бүртгэл болон сургалтын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж “Гэр бүл-Баяр хөөр” Төрийн бус байгууллагатай харилцан уялдаа холбоотой ажилласан.

Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр иргэн 265 аж ахуй нэгж байгууллагыг шалгаж Тамхины хяналтын тухай хуулийг зөрчиж, хориглосон цэгт утаат тамхи худалдан борлуулах, ширхэглэн худалдаалах, олон нийтийн газар утаат тамхи татах зэрэг 39 зөрчлийг илрүүлэн иргэнийг Зөрчлийн тухай хуулинд зааснаар 2765000 төгрөгөөр торгож хураагдсан 281 хайрцаг, 950 ширхэг тамхийг Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох орон тооны бус зөвлөлд шилжүүлэн ажилласан.

Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 423 иргэн 46 албан тушаалтан 567 аж ахуй нэгж байгууллагыг шалгаж Тамхины хяналтын тухай хуулийг зөрчиж, хориглосон цэгт утаат тамхи худалдан борлуулах, ширхэглэн худалдаалах, олон нийтийн газар утаат тамхи татах зэрэг зөрчлийг илрүүлэн иргэнийг 1650000 төгрөгөөр торгож хураагдсан 246 хайрцаг 799 ширхэг тамхийг Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох орон тооны бус зөвлөлд шилжүүлэн ажилласан.

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар бүлэг “Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа”-ны 24 дүгээр зүйл “Олон нийтийн цагдаагийн ажилтан” үйл ажиллагааны хүрээнд хэлтсийн хариуцсан 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийт 10 олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллаж байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

С.БАТ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ө.ЭРДЭНЭХҮҮ